**Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн**

***Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго***

Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

***Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй***

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.4 дүгээр заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу тус яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн болно. Журмын 6.2.1, 6.2.2 болон 6.7 дугаар заалтуудыг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Эрүүл мэндийн яамны 2022 оны төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үнэлгээг бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцон гаргасан болно.

***Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн***

Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 198 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс гадна “Төсвийн тухай хууль”-ийн 69 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх үүднээс Дотоод аудитын 2022 оны төлөвлөгөөнд 21 ажил төлөвлөн, нийт 219 үйл ажиллагааг төлөвлөжээ.

Төлөвлөсөн 219 ажлаас 129 ажил буюу нийт ажлын 58.9%-нь 100 хувийн хэрэгжилттэй; 16 ажил буюу 7.3%-нь 90 хувийн хэрэгжилттэй, 15 ажил буюу 6.8%-нь 70 хувийн хэрэгжилттэй, 17 ажил буюу 7.8%-нь 50 хувийн хэрэгжилттэй, 31 ажил

буюу 14.2%-нь 30 хувийн хэрэгжилттэй, 11 ажил буюу 5.0%-нь 0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 1 . Хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарын үзүүлэлт

| Үнэлгээ | Арга хэмжээ | |
|---|---|---|
| | Тоо | Эзлэх хувь |
| **100 хувь** буюу бүрэн хэрэгжсэн | 129 | 58.9 |
| **90 хувь** буюу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа | 16 | 7.3 |
| **70 хувь** буюу тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа | 15 | 6.8 |
| **50 хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн | 17 | 7.8 |
| **30 хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа | 31 | 14.2 |
| **0 хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй | 11 | 5.0 |
| Нийт | 219 | 100.0 |
| Дундаж | 76.1% | |

Хүснэгт 2. 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

| № | 2022 онд төлөвлөсөн нийт ажил | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100% | 90% | 70% | 50% | 30% | 0% |
| БТГ | 53 | 23 | 2 | 8 | 4 | 14 | 2 |
| НЭМГ | 30 | 14 | 4 | 1 | 5 | 5 | 1 |
| СЭЗГ | 34 | 16 | 6 | 1 | 2 | 3 | 6 |
| ТЗУГ | 39 | 30 | 1 | 2 | 4 | 1 | 1 |
| ЭТҮГ | 27 | 11 | 2 | 3 | 2 | 8 | 1 |
| ХШҮДАГ | 36 | 35 | 1 | | | | |
| Нийт | 219 | 129 | 16 | 15 | 17 | 31 | 11 |

Зураг 1. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь (нэгжээр)




Зураг 2. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь (чиг үүргээр)



Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр **“0” хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй 11 ажил байна.

1. ЭМЯГТ 1, ЗГҮАХ 1.1.1.5 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. НЭМГ
2. ЭМЯГТ 11, ЗГҮАХ 1.1.3.5, МУТЖҮЧ-2.2.1, МУХТ 1.1.3.5 Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна. БТГ
3. ЭМЯГТ 28, ЗГҮАХ 2.1.2.2 Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна. ЭТҮГ
4. ЭМЯГТ 29, ЗГҮАХ 2.1.3.2 Зүрх судасны төв байгуулж, үндэсний баг бүрдүүлнэ. СЭЗГ
5. ЭМЯГТ 30, ЗГҮАХ 2.1.3.3 Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна. СЭЗГ
6. ЭМЯГТ34, ЗГҮАХ 2.1.3.7 Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна. СЭЗГ
7. ЭМЯГТ 46, ЗГҮАХ 2.1.4.3 Яаралтай тусламж үйлчилгээнд агаарын үйлчилгээг (нисдэг тэрэг) нэвтрүүлнэ. СЭЗГ
8. ЭМЯГТ 59, ЗГҮАХ 2.1.10.1 Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж батлуулна. БТГ
9. ЭМЯГТ 119, ЗГҮАХ 2.1.11.2 Ховд аймгийн БОЭТ-ийн барилгын өргөтгөл барина. СЭЗГ
10. ЭМЯГТ 127, ЗГҮАХ 2.1.14.1, МУТЖҮЧ-2.2, МУХТ 2.1.29 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно. СЭЗГ
11. ЭМЯГТ 184, Тоон гарын үсэг нэвтрүүлнэ. ТЗУГ

Эдгээрээс Зүрх судасны төвийн барилга, Геронтологийн төвийн барилга, Хавдар судлалын үндэсний төвийн салбарын барилга усгралтад “2022 оны төсвийн тухай хууль”-иар төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжийн жагсаалтад батлагдаагүй байна. Сүрьеэгийн эмнэлгийн барилгын хувьд худалдан авах ажиллагаанд маргаан гарсан тул шүүхийн шийдвэрийг хүлээж байна. Ховд аймгийн БОЭТ-ийн барилгын өргөтгөлийг “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд хийхээр төлөвлөсөн ба барилгын ажлын зураг төслийг гүйцэтгэхээр “Татах хүч” ХХК

шалгарч 2022 оны 8 дугаар сард гэрээ байгуулан ажиллаж байна. Ажлын явц 40 хувьтай байгаа ба 2023 оны эхний хагас жилд багтаан Ховд аймгийн БОЭТ-ийн өргөтгөлийн зураг төсөл хийгдэхээр төлөвлөж байна. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хувьд зураг төсөл хийгдэж байна.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр **“30” хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 31 ажил байна. Үүнд:

1. ЭМЯГТ 3, ЗГҮАХ1.1.2.6 Хүн амыг коронавирсут халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамруулна. НЭМГ
2. ЭМЯГТ 8, ЗГҮАХ 1.1.3.2, МУТЖҮЧ-2.2.1, МУХТ 1.1.3 Шаардлагатай аймгуудад ЗӨСТ, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна. НЭМГ
3. ЭМЯГТ 14, ЗГҮАХ 1.1.4.1 Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл,тэдгээрийн түүхий эд,оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүй-жүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулна. ЭТҮГ
4. ЭМЯГТ 21, ЗГҮАХ 2.1.1.2, МУТЖҮЧ-2.2.1 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлнэ. НЭМГ
5. ЭМЯГТ 24, УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1, ЗГҮАХ 2.1.1.5 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.ЭТҮГ
6. ЭМЯГТ 27, МУТЖҮЧ-2.2.2 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын шүдний кабинетын тоног төхөөрөмжийн ашиглалт, хүний нөөцийн бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, кабинетын үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ. НЭМГ
7. ЭМЯГТ 31, ЗГҮАХ 2.1.3.4 Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.
8. ЭМЯГТ 33, ЗГҮАХ 2.1.3.6 Халдварт өвчин судлалын үндэсний тевийн цогцолбор салбар II байгуулна. СЭЗГ
9. ЭМЯГТ 35, ЗГҮАХ 2.1.3.8 Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барьна. СЭЗГ
10. ЭМЯГТ 53, ЗГҮАХ 2.1.5.5 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчилнэ. ЭТҮГ
11. ЭМЯГТ 54, ЗГҮАХ 2.1.5.6 Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.БТГ

12. ЭМЯГТ 55, ЗГҮАХ 2.1.5.7 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхийг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна. БТГ
13. ЭМЯГТ 70, ӨОУ-ын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. БТГ
14. ЭМЯГТ 72, МУТЖҮЧ 2.7.4. Хүний генетикийн оношилгоо, эмчилгээний генийн сангийн тухай хууль боловсруулна. БТГ
15. ЭМЯГТ 75, МУТЖҮЧ 2.2.5, ЗГҮАХ 2.1.7.1, МУЖТ 2.1.27 Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулна. БТГ
16. ЭМЯГТ 77, ЗГҮАХ 2.1.7.3 Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүлнэ. БТГ
17. ЭМЯГТ 81, ЗГҮАХ 2.1.7.7 Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ. БТГ
18. ЭМЯГТ 82, ЗГҮАХ 2.1.7.8 ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхижуулна. БТГ
19. ЭМЯГТ 86, Эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн санг бий болгох, програм хангамж нэвтрүүлнэ. БТГ
20. ЭМЯГТ 88, ЗГҮАХ 2.1.7.11 Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-гийн орлогыг нэмэгдүүлнэ. БТГ
21. ЭМЯГТ 98, ЗГҮАХ 2.1.8.4 Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ. ЭТҮГ
22. ЭМЯГТ 108, Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулж батлуулна. БТГ
23. ЭМЯГТ 109, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулна. бТГ

24. ЭМЯГТ 115, Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлтийг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан, олон улсын стандартад нийцүүлэн хийнэ. БТГ
25. ЭМЯГТ 124, МУТЖҮЧ-2.2.2 БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээг зохион байгуулах журмыг боловсруулж, батлуулна. НЭМГ
26. ЭМЯГТ 128, ЗГҮАХ 2.1.10.1 Хүний эрхийн асуудлаар Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулна. ТЗУГ
27. ЭМЯГТ 129, ЗГҮАХ 2.1.3.1, МУТЖҮЧ-2.2.3, Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг боловсруулна. ЭТҮГ
28. ЭМЯГТ 132, ЗГҮАХ 2.1.13.1, Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг турших, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ. БТГ
29. ЭМЯГТ 135, МУТЖҮЧ 2.2.2 Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн стратеги төлөвлөгөө (2022-2030) боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан. ЭТҮГ
30. ЭМЯГТ 136, Сувилахуйн тусламж, үйлчилгээний стратеги төлөвлөгөө (2022-2026) боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулна. ЭТҮГ
31. ЭМЯГТ 153, МУХТЖҮЧ 2.2.7; Уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэлийн эрхзүйн орчинг шинэчилнэ. ЭТҮГ

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр **“50” хувь** буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 15 ажлууд:

1. ЭМЯГТ 23, ЗГҮАХ 2.1.1.4, МУТЖҮЧ-2.2.2, МУХТ 2.1.20 “Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулна. НЭМГ
2. ЭМЯГТ 47, ЗГҮАХ 2.1.4.4 Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ. СЭЗГ
3. ЭМЯГТ 49, ЗГҮАХ 2.1.5.2, МУХТЖҮЧ 2.2.1 МУ-ын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна. НЭМГ
4. ЭМЯГТ 52, ЗГҮАХ 2.1.5.4 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулна. НЭМГ
5. ЭМЯГТ 85, Эрүүл мэндийн технологийн мэдээллийн нэгдсэн сан байгуулна.БТГ
6. ЭМЯГТ 94, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулна. ЭТҮГ

7. ЭМЯГТ 96, ЗГҮАХ 2.1.8.2 Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийнэ. БТГ
8. ЭМЯГТ 104, ЗГ-ын2020 оны 216 тогтоол. Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги боловсруулна. БТГ
9. ЭМЯГТ 114, ЗГҮАХ 2.1.9.7 Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ. БТГ
10. ЭМЯГТ 118, "Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна. ТЗУГ
11. ЭМЯГТ 122, ЭМЯ-ны албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлнэ. ТЗУГ
12. ЭМЯГТ 140, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартуудыг шинэчлэн боловсруулж батлуулна. ЭТҮГ
13. ЭМЯГТ 145, Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин бодолтын загвар боловсруулж батлуулна. СЭЗГ
14. ЭМЯГТ 152, ЗГҮАХ 2.1.14.1, МУХТЖҮЧ-2.2, МУХТ 2.1.29 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно. НЭМГ
15. ЭМЯГТ 158, ЗГҮАХ 2.3.10.1, МУХТЖҮЧ 2.1.9 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлнэ. НЭМГ
16. ЭМЯГТ 170, Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл болон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төлбөрийн жишиг тогтоосон журмыг батлуулна. ТЗУГ
17. ЭМЯГТ 171, Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна. ТЗУГ

## Дөрөв. Дүгнэлт

1. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 76,1 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс:
    - 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 129 үйл ажиллагаа байна.
    - 90 хувь буюу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа 16 үйл ажиллагаа байна.

- 70 хувь буюу тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа 15 үйл ажиллагаа байна.
- 50 хувь буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн 17 үйл ажиллагаа байна.
- 30 хувь буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа 31 үйл ажиллагаа байна.
- 0 хувь буюу тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй 11 үйл ажиллагаа байна.

2. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 76.1 хувийн хэрэгжилттэй байгаа нь "тодорхой үр дүнд хүрсэн" буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илэрхийлж байна.
3. Үнэлгээний дундаж хувь 76.1 хэдий ч нийт төлөвлөсөн ажлын 30.0% нь 0-50 хувийн хэрэгжилттэй байгаа тул үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

## Тав. Зөвлөмж

1. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 0-50 хувийн үнэлгээтэй үнэлэгдсэн 59 ажлыг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин тусгаж, эрчимжүүлэх
2. Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг 4-6 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэл үүсч болзошгүйг анхаарч ажиллах
3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үйл ажиллагааг Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлох

4. Дээрх бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг яамны болон газар хэлтсийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан эсэхэд газар хэлтсийн дарга нар хяналт тавьж ажиллах
5. УИХ, Засгийн газраар хэлэлцүүлэх асуудлууд, ялангуяа хуулиудад нэмэлт, өөрчлөлт, шинээр боловсруулах хуулиудын явцыг эрчимжүүлж, хугацаанд нь Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхэд анхаарах
6. Төлөвлөгөөний хугацаа, шалгуур үзүүлэлтийг оновчтой, тодорхой болгох
7. Тайлагналтыг оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу товч, тодорхой тайлагнаж байх

Эрүүл мэндийн яам
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
2002-12-23

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | |
| 1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ 1.1.1.5 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. | Мэдээлэл сурталчилгааны тоо, төрөл, хандалтын тоо | - | Мэдээлэл сурталчилгааг тогтмол хийж, сургалт зохион байгуулсан байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | ХНХЯ-аас жил бүр зохион байгуулдаг “Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2021” шалгаруулах ажлын хэсэгт ажилласан. Уралдаанд материал ирүүлэх тухай 6/145 дугаар албан тоотыг аймаг, нийслэлийн ЭМГ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хүргүүлсэн. ГССҮТ уралдааны дэд байранд шалгарсан.<br>Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 420 холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан “Нэн түрүүнд ХАБ-2022” бага хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан.<br>ДЭМБ-ын санхүүжилтээр “Хар тугалганы хордлогоос урьдчилан сэргийлэх, хойшид авах арга хэмжээ” сэдэвт | 0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | салбар дундын хэлэлцүүлэг, уулзалтыг 2022 оны 10 сарын 27-ны өдөр зохион байгуулсан. | |
| 2. | ЗГҮАХ 1.1.2.4 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна. | Вакцинжуулалтад хамрагдалтын хувь | Вакцинжуулалтад хамрагдалтын хувь 97% байсан. | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80-аас доошгүй хувийг улирлын томуугийн вакцинжуулалтад бүрэн хамруулсан байна. | IV улирал | СЭЗГ-СДХ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/68 дугаар тушаалаар томуугийн 500,000 хүн/тун вакцины хуваарийг батлуулсан. 2022 оны 10 дугаар сарын 12-нд улсын төсвийн хөрөнгөөр 500,000 хүн/тун, олон улсын байгууллагын санхүүжилтээр 45,000 хүн/тун томуугийн вакцин хүлээн авч, 1-ээс дээш насны хүүхэд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн ажилтны 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Эрүүл мэндийн сайдын А/512 дугаар тушаалын дагуу вакцинжуулж эхэлсэн. 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар томуугийн дархлаажуулалтад 1-16 насны 226.240 хүүхэд хамрагдахаас 222.645 хүүхэд хамрагдаж, хамралтын хувь 98.4 хувь байна. Томуугийн вакцинд 7,6 тэрбум төгрөг зарцуулсан. | 100 |
| 3. | ЗГҮАХ1.1.2.6 Хүн амыг коронавирсут халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинд хамруулна. | Вакцинжуулалтад хамрагдсан хүн амын эзлэх хувь | Ковид-19-ын вакцины зорилтот бүлгийн 1-р тунгийн хамралт 96,1% 2-р | Хүн амын 20 хувийг коронавируст халдварын эсрэг вакцины нэмэлт 4 дүгээр тунд хамруулсан байна. | I- IV улирал | НЭМГ-ХӨХ | “Нэмэлт тунгийн вакцинжуулалтыг эрчимжүүлж, ард иргэдийн хамралтыг нэмэгдүүлэх төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайдаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулсан. Нэмэлт тунг | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тунгийн хамралт 91,8%, 3-р тунгийн хамралт 47,9% байна. | | | | эрчимжүүлэхээр 8 удаагийн албан бичгийг хүргүүлж, 14 яам, бүх шатны эрүүл мэндийн болон боловсролын байгууллагуудтай хамтран ажилласан.<br>Сайн дурын үндсэн дээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг үндэслэн 12-17 насны хүүхдийг 2 дугаар тунг хийлгэснээс хойш 5 сарын дараа нэмэлт тунгаар вакцинжуулах арга хэмжээг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын А/314 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулсан.<br>Улсын хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 06-ны байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины<br>1-р тунгийн хамралт нийт хүн амын 68,9%, 2-р тунгийн хамралт 66,0%, 3-р тунгийн хамралт 31,9%, 4-р тунгийн хамралт 4,1% буюу 139,469 хүн хамрагдсан байна. | |
| 4. | ЗГҮАХ 1.1.2.7 Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, | Геномын бүтэц, дархлаажуулал-тын дараах дархлаа | - | Монгол Улсад зөөвөрлөгдөж ирсэн коронавируст халдварын геномын бүтцийг | I улирал | БТГ-СТХ | Вирусийн геномын судалгаа 8, вакцины 12 судалгааны үр дүнг 2022 онд хүлээн авсан.<br>Вирусийн геномын:<br>1. Монгол Улс дахь SARS-CoV 2 вирусийн геномын бүтцийг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээж авна. | тогтцын судалгааны үр дүн | | тодорхойлсон байна. Дархлаажуулал-тын дараах дархлаа тогтцын байдлыг үнэлж, дархлаа тогтох хугацааг тодорхойлж, зөвлөмж, заавarт тусгагдсан байна. | | | тодорхойлох, молекул эпидемиологийн онцлогийг тогтоон, онош тандалт, сэргийлэлтийн манай орны нөхцөлд тохирсон аргачлал зөвлөмж гаргах<br>2. Монгол Улсад SARS-CoV-2 голомтолсон халдварын геномын судалгаа<br>3. SARS-CoV-2 вирусийн хувилбарыг илрүүлэх судалгаа<br>4. SARS-CoV-2 вирусийн хувилбарын тархалтыг тодорхойлох, молекул эпидемиологийн судалгаа<br>5. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн SARS-CoV-2 вирусийн геномын шинжийг судалсан дүн<br>6. БХ-ПГУ шинжилгээний аргаар SARS-CoV-2 вирусийн хувилбарыг илрүүлэх судалгааны зарим үр дүнгээс<br>7. Монгол Улсад КОВИД-19 цар тахал үүсгэсэн Дельта хувилбарын SARS-CoV-2 вирусийн геномыг судалсан дүн<br>8. Монгол Улсад голомтлон тархаж буй SARS-CoV-2 омогт БХ-ПГУ аргаар өвөрмөц мутаци илрүүлэх, геномын судалгаа болон | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нуклейн хүчлийн дараалал тогтоох шинжилгээний шинэ технологи нэвтрүүлэх судалгааны дүн<br>Вакцины судалгаа:<br>1. КОВИД-19 эсрэг вакцины гурав дахь сэргээх тунгийн дарах дархлааны хариу урвал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг судлах нь<br>2. КОВИД-19 вакцины гуравдугаар тунгийн дараах гематологи, биохими, коагулограммын шинжилгээний үзүүлэлтүүдийг үнэлсэн дүн<br>3. КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа<br>4. Хоёр тун Вероцелл вакцины дараа гомологи болон гетерологи вакцинаар дархлаа сэргээх гуравдугаар тун хийлгэсэн оролцогчдыг цусны шинжилгээний үзүүлэлтүүдийг хугацааны хамаарлаар үнэлсэн дүн<br>5. Ковишилд болон Вероцелл вакцинаар вакцинжуулсны дараах SARS-CoV-2-ын эсрэг үүссэн эсрэг биеийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | түвшинг харьцуулсан дүн<br>6. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дараах дархлаа тогтоцын судалгаа<br>7. КОВИД-19-ийн халдвар болон вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын үнэлгээ<br>8. КОВИД-19 вакцины гурав дахь тунгийн дараах дархлааны хариу урвал болон урвал хүндрэлийг судлах нь<br>9. КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа<br>10. Жирэмсэн эмэгтэйд КОВИД-19-ын вакцины аюулгүй байдал ба үр нөлөөг судлах нь<br>11. КОВИД-19 вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын хугацаанаас хамаарах өөрчлөлтийнг үнэлэх судалгаа<br>12. SARS-CoV-2 вирусийн эсрэг вакцинуудын үр нөлөө, хүн амын цахим мэдээллийн санд суурилсан ретроспектив кохорт судалгаа | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Судалгааны үр дүнг 2022-11-14-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанд танилцуулсан. | |
| 5. | ЗГҮАХ 1.1.2.8 Олон улсын байгууллагатай хамтарсан коронавируст халдвар (КОВИД-19) судалгааны ажлуудыг эхлүүлэх, үр дүнг хүлээн авна. | Олон улсын байгууллагатай хамтарсан коронавируст халдвар (КОВИД-19) судалгааны ажлуудын тайлан | - | Хүн амын коронавирусийн халдварын тархалтыг ийлдэс судлалын аргаар тодорхойлсон байна. Эмнэлзүйн зураглал өвчний явц, халдвартай тохиолдлуудын хугацааг тодорхойлсон байна. | I улирал | БТГ-СТХ | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтыг хүн амд суурилан насны бүлэг тус бүрээр ийлдэс судлалын аргаар судлах тархвар зүйн судалгааны ажил 2021-2023 оны хийгдэхээр Эмнэлзүйн зураглал өвчний явц, халдвартай тохиолдлуудын хугацааг тодорхойлсон байна. ДЭМБ-ын санхүүжилттэй 5 төсөл хэрэгжин дуусч үр дүнг Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын өдрийн хурлаар “КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ” хүрээнд эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн төслүүдийн үр дүнг танилцуулан хүлээлгэн өгсөн. ЭМЯ, ШУТЗ-ийн 2022.12.23-ны өдрийн хурлаар мөн төслүүдийн үр дүнг хэлэлцэн хүлээлгэж өгсөн. Судалгааны үр дүнгийн дэлгэрэнгүй тайланг гарын авлага болгон эмхэтгэтгэн гаргаж албан хэрэгцээнд ЗГ, УОК, харьяа байгууллагуудад хүргүүлсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Коронавируст халдварын талаарх нөхцөл байдлын мэдээллийг бэлтгэж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | Мэдээллийн тоо | Өдөр бүр гаргадаг. | Коронавируст халдварын талаарх нөхцөл байдлын мэдээллийг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргэсэн байна. | I-IV улирал | БТГ-СТХ | Коронавируст халдварын нөхцөл байдлын талаарх мэдээллийг 5 чиглэлээр өдөр бүр бэлтгэн сайд, УОК, ТНБД, яамны бусад удирдах албан тушаалтнуудыг мэдээллээр ханган ажиллаж байна.<br>. | 100 |
| 7. | ЗГҮАХ 1.1.3.1<br>МУТЖҮЧ-2.4.1<br>МУХТ 1.1.2<br>Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | Бэлэн байдлын үеийн нөөцийн хэмжээ | - | Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж нөөцийг шинэчилсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс дараах байдлаар бүрдүүлсэн:<br>1.АХБ-ны санхүүжилтээр 50,2 сая төгрөгийн үнэ бүхий 3,200 ширхэг моксифлоксациныг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>2.Япон Улсын Засгийн газрын санхүүжилтээр:<br>-1,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг унтуулгын аппарат болон дагалдах хэрэгслийг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хувиарласан<br>-17,0 сая төгрөгийн үнэ бүхий 6 ширхэг эмнэлгийн зориулалт бүхий хөргөгч, 57,0 сая төгрөгийн үнэ бүхий эм болон эмнэлгийн хэрэгслийг хүлээн авсан.<br>-1,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эх, нярайн тусламж | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээнд ашиглах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөв.<br>-595,9 сая төгрөгийн үнэ бүхий явуулын эмнэлэгт суурилуулах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч эмнэлгүүдэд хуваарилсан.<br>-3,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг С хэлбэрт рентген аппаратыг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.<br>-145,5 сая төгрөгийн үнэ бүхий 2 генийн дараалал тогтоогч 9,8 сая төгрөгийн үнэ бүхий генийн дараалал тогтоох шинжилгээний өгөгдлийг унших 2 зөөврийн компьютер, тог баригч, 207,0 сая төгрөгийн үнэ бүхий урвалжуудыг хүлээн авч УНТЭ болон ЗӨСҮТ-д тус тус хуваарилан өгсөн.<br>-1,2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 548 ширхэг зөөврийн компьютер болон дагалдах хэрэгслийг хүлээн авч улсын хэмжээнддархлаажуулалтын цэгүүдэд хуваарилан өгсөн.<br>-33,2 сая төгрөгийн үнэ бүхий 42 ширхэг пульсоксиметрыг хүлээн авч холбогдох эрүүл | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>-2,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 200,000 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч, нөөцөд авах тухай тушаалыг батлуулсан.<br>-1,2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг уушгины дуран, 3 ширхэг уушгины мэс заслын багаж хэрэгслийн багцыг хүлээн авч ХӨСҮТ-д хуваарилан олгосон.<br>-536,3 сая төг-ийн үнэ бүхий 3 явуулын эмнэлэг, ариун цэврийн байгууламжийн чингэлэг, 908,4 сая төг-ийн үнэ бүхий 3 явуулын эмнэлгийг хүлээн авч, эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахыг хариуцаж байгаа ЗӨСҮТ-д Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилан олгов.<br>-449,5 сая төг-ийн үнэ бүхий 150,000 ширхэг аюулгүй хайрцгийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/430 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгуулагуудад хуваарилан олгов.<br>-434,8 сая төгрөгийн үнэ бүхий 60 ш зөөврийн хөлдөөгчийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/433 дугаар тушаалаар хуваарилан олгов. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэг жилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -1,3 тэрбум төг-ийн үнэ бүхий 2 ширхэг барокамерыг хүлээн авч ХӨСҮТ, ГССҮТ-ийн Түлэнхийн төвд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/391 дүгээр тушаалаар хуваарилан олгов<br>-221,5 сая төг-ийн үнэ бүхий 1 ширхэг вакцин тээвэрлэх зориулалт бүхий 1 ширхэг автомашиныг хүлээн авч, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны хэрэгцээнд зориулж Эрүүл мэндийн сайдын А/419 дүгээр тушаалаар хуваарилан олгов<br>-5,3 тэрбум төг-ийн 500,100 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч, эмнэлгүүдэд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/556 дугаар тушаалаар хуваарилан олгов.<br>-738,2 сая төг-ийн үнэ бүхий 12 ширхэг С хэлбэрт рентген аппаратын тог баригчийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/327 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов.<br>-КОВАКС механизмын хүрээнд SARS-CoV-2 халдварын эсрэг 1,030,000 тун 5-11 насны хүүхдийн 302,400 тун хүлээн авсан.<br>3.НҮБ-ын Хүүхдийн Сангийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | буцалтгүй тусламжийн хүрээнд:<br>-85,9 сая төгрөгийн үнэ бүхий 6,000 ширхэг нэг удаагийн халатыг хүлээн авч нөөцөд авсан.<br>-862,3 сая төгрөгийн үнэ бүхий 787,500 ширхэг дексаметазон тариаг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>-356,9 сая төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслүүдийг хүлээн авч нөөцөд авсан.<br>-650,3 сая төг-ийн үнэ бүхий 32,500 ширхэг FFP2/N95 нарийн шүүлтүүрт амны хаалт болон 13,000 хайрцаг буюу 1,3 сая ш нэг удаагийн бээлийг хүлээн авч нөөцөд авсан.<br>-1,9 тэрбум төг-ийн үнэ бүхий 199,997 ширхэг хамгаалалтын нүдний шилийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/454 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов<br>-173,5 сая төг-ийн үнэ бүхий 120 ширхэг пульсоксиметр, 160 ширхэг зайнаас халуун хэмжигчийг хүлээн авсан.<br>-20,000 ширхэг нэг удаагийн хамгаалалтын хувцасны иж бүрдэл, 100,000 ш нэг удаагийн халад болон 20,000 ш нүүрний | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаалтыг хүлээн авч ЭМЯ-ны нөөцөд авав.<br>-113,7 сая төг-ийн үнэ бүхий 1,038 хайрцаг моксифлоксацин тариаг 10 дугаар сард хүлээн авч, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нөөцөд авав<br>-981,1 сая төг-ийн үнэ бүхий 30,000 ширхэг нүүрний хаалт болон 30,000 ширхэг хамгаалалтын комбинезон 12 дугаар сард хүлээн авав. | |
| 8. | ЗГҮАХ 1.1.3.2<br>МУТЖҮЧ-2.2.1<br>МУХТ 1.1.3<br>Шаардлагатай аймгуудад ЗӨСТ, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна. | Байгуулсан ЗӨСТ болон хил дагуух боомтод байгуулсан тандалтын нэгжийн тоо | Тооцоо, судалгаа хийгдсэн. | 2 аймагт ЗӨСТ, хил дагуух 10 боомтод тандалтын нэгжийг байгуулсан байна. | II, IV улирал | НЭМГ-ХӨХ | Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт ЗӨСТ байгуулах талаар үндэслэл, танилцуулга, шаардагдах төсвийг 2023 оны төсвийн төсөлд тусгасан ч 2023 онд шинээр барилга байгууламж барихгүй шийдвэртэй холбоотой хойшилсон.<br>БНХАУ-ын ЗГ-ын буцалтгүй тусламжаар бүрэн автомат ПГУ шинжилгээний төхөөрөмж (FQD-G1600)-ийн иж бүрдлээр Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Бичигт, Замын-Үүд автозамын боомтуудыг хангах ажил хийгдэж байна. Гашуунсухайт боомтын молекул биологийн лабораторийн үйл ажиллагаа эхэлсэн, бусад боомтын лабораторийн тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн ч гаалийн хөнгөлөлт, | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чөлөөлөлтөөс хамаарч хүлээн аваагүй байна.<br>АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийж хүргүүлсэн бөгөөд төслийн удирдах хорооны хурлаар дэмжигдэж, АХБ-ны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд 2023 онд нийлүүлэгдэнэ. | |
| 9. | ЗГҮАХ 1.1.3.3 МУХТЖҮЧ-2.2.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо | - | Төлөвлөгөөт сургалт сурталчилгаа бүрэн хийгдсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ, УСХЗХ | ДЭМБ-ын санхүүжилтээр "Цахим орчинд эрсдэлийн үеийн мэдээллийг үнэлэх, контент бэлтгэх, хөгжүүлэх, түгээх чадварыг нэмэгдүүлэх нь" сэдэвт онол практик хосолсон сургалтыг зохион байгуулж, ЭМЯ-ны харьяа эмнэлэг, төв, аймаг, нийслэлийн ЭМГ-ын эрсдэлийн харилцаа холбооны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан.<br>Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэх 70 инфографик, 18 хөдөлгөөнт постерын эхийг бэлтгэн ЭМЯ- | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ны цахим хуудас болон ФБ хуудсанд байршуулан сурталчилж байна.<br>Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 335 инфографик, 12 хөдөлгөөнт инфографик, 8 видео шторк бэлтгэн ЗӨСҮТ-ийн цахим болон ФБ хуудсаар түгээн сурталчилсан.<br>“Хачгаар дамжих халдвар”, “Тарваган тахал”, “Коронавируст халдвараас сэргийлье” сэдэвт 3 төрлийн зурагт хуудас боловсруулж, нийт 3000 ширхэгийг хэвлүүлэн голомтот бүхий эрсдэлт бүлгийн хүн амд түгээсэн. АХБ-ны дэмжлэгтэйгээр 15 интерактив хичээл, иргэд олон нийтэд зориулсан зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх 8 видео шторкыг боловсруулан нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгаанд ашиглаж байна.<br>“Энгийн дадал-Эрүүл амьдрал” сэдвийн дор эмийн бус сэргийлэлтийн аргыг сурталчилсан 23 төрлийн инфографик, 5 төрлийн анимэйшн бүтээн ЭМЯ, НЭМҮТ-ийн цахим болон фейсбүүк хуудсанд байршуулан сурталчилж, 340 мянга гаруй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүн үзэж, 1,426 хүн лайк дарж, хуваалцсан байна.<br>Коронавируст халдвар (КОВИД-19), бусад халдварт өвчин, дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс сэргийлэх талаар 18 цуврал видео, 20 контент, 32 инфографик, 260 текстэн зөвлөгөөг давхардсан тоогоор 888.978 хүнд хүргэсэн.<br>Дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс сэргийлэх 10 төрлийн зурагт хуудсыг 38.000 ширхэг хэвлүүлж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад түгээн сурталчилсан.<br>Улирлын томуу өвчнөөс сэргийлэх талаар 20 цуврал контент бэлтгэж, 843 ерөнхий боловсролын сургууль, 1253 цэцэрлэг, 64 их, дээд сургууль, 76 коллежийн анги, танхимын дэлгэц, аймаг, дүүргийн эрүүл мэндийн газруудын цахим сувгаар түгээн 460.337 хүнд хүрсэн. | |
| 10. | ЗГҮАХ 1.1.3.4<br>МУТЖҮЧ-2.2.1<br>МУХТ 1.1.3<br>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах | Нөөцийн агуулахын барилгын явцын хувь | - | Нөөцийн агуулахын барилгын ажлыг эхлүүлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг ЗӨСҮТ-ийн эзэмшлийн газрын 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинээр барьж, ашиглалтад оруулна. | | | | | | хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт барьж, ашиглалтад оруулсан.<br>АХБ-ны "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5" төслийн хүрээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд ЗӨСҮТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахын барилга барихад 6.7 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 1.6 тэрбум төгрөг нийт 8.3 тэрбум төгрөг санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 11. | ЗГҮАХ 1.1.3.5<br>МУТЖҮЧ-2.2.1<br>МУХТ 1.1.3.5<br>Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна. | ЗГ-ын хуралдааны шийдвэр | - | Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулагдаж үйл ажиллагаа эхэлсэн байна. | III улирал | БТГ | "Өвчний хяналт, сэргийлэлтийн төв" байгуулах хууль эрх зүйн орчныг судлах, холбогдох дүрэм, журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/229 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, тандалт, судалгааны нэгж бүхий 8 байгууллагаас судалгаа авч, дүн шинжилгээ хийж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө | 0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"- д Өвчний хяналт сэргийлэлтийн төвийн барилгын асуудал тусаагүйтэй холбогдуулан өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах асуудлыг хойшлуулах шийдвэр гаргуулахаар Удирдлагын зөвлөлийн 2022 оны 12 сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | |
| 12. | ЗГҮАХ 1.1.3.6 Шинэ коронавирусын халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | Оношилгоонд ашигласан дотоодын оношлуурын тоо | - | Оношлуурын бүрдлийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | IV улирал | БТГ-СТХ | - Академич, Биологийн шинжлэх ухааны доктор профессор Д.Оюунсүрэнгийн "Шинэ төрлийн SARS-CoV2 вирусийн эсрэг бие илрүүлэх оношлуур гарган авах"<br>- АУ-ны доктор Ж.Зандраагийн "SARS-CoV2 илрүүлэх нуклейн хүчилд тулгуурласан оношлуур үйлдвэрлэх, технологи боловсруулж туршин нэвтрүүлэх, үйлдвэрлэл явуулах"<br>- АУ-ны доктор Г.Батбаатарын "Шүлсэнд SARS-CoV2 -ийг илрүүлэх RT-PCR оношлуур бүтээх, эмнэлзүйн практикт нэвтрүүлэх" судалгааны ажлын санхүүжилтийг ШУТС шийдвэрлэсэн. Оюуны | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өмчийн гэрчилгээ, ЭМЯ-ны ШУТЗ-ийн хурлаар орж бүртгүүлсэн.<br>Дотооддоо дээрх оношлууруд хийгдэж эдийн засгийн эргэлтэнд орсон. | |
| 13. | ЗГҮАХ 1.1.3.7<br>МУТЖҮЧ-2.2.3<br>Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн молекул биологийн лабораторийн чадавхийг бэхжүүлнэ. | Чадавхийг бэхжүүлсэн лабораторийн тоо | 21 аймаг, 8 дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд лабораторийг байгуулсан. | Хилийн боомтуудын бүсэд БХ-ПГУ төхөөрөмжтэй болж, лабораторийн чадавхи нэмэгдсэн байна. | I-IV улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ | Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод нуклейн хүчил ялгах 2 аппарат, ПГУ тодорхойлох 4 аппаратын хүчин чадал бүхий лабораторийг байгуулж, хүлээлгэн өгсөн. Лабораторид ХӨСҮТ-ийн эмч мэргэжилтнүүд ажиллаж байна. Хилийн боомтуудад нэн шаардлагатай ПГУ-ын шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, коронавирусийг тодорхойлох оношлуур, нуклейн хүчил ялгах оношлуур зэрэг 2,6 тэрбум төгрөгийн молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмж, дагалдах урвалж, оношлуурыг хүлээн аваад байна. | 70 |
| 14. | ЗГҮАХ 1.1.4.1<br>Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, | Шинэчлэн батлагдсан жагсаалт | - | Шинэчилсэн жагсаалтын дагуу татвараас чөлөөлөгдөж, хариу арга | I-IV улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ НЭМГ-УСХЗХ | "КОВИД-19" халдварт вирусийн оношилгоо, эмчилгээнд зориулж импортлох оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлгийн хэрэгсэл,тэдгээрийн түүхий эд,оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүй-жүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулна. | | | хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | | | халдваргүйжүүлэлтийн бодисыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр дуусгавар болсон. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулж, үзэл баримтлалын дагуу хуулийн төсөл боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 1а/2065 тоот албан бичгээр бүх яамдаас санал авсан. Сангийн сайдын 2022 оны 01/3577 тоот албан бичгээр "Эдийн засаг, төсвийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан дээрх бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлөх шаардлагагүй" гэсэн хариу ирүүлснээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон.<br>Засгийн газрын 2020 оны 132 дугаар тогтоолоор баталсан "Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх коронавируст | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | халдвар (COVID-19)-ын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж байгаа оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт"-ын хавсралтад дурьдсан "ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалт"-ыг шинэчлэхээр санал боловсруулж байна. | |
| 15. | ЗГҮАХ 1.1.15.1 Эрүүл мэндийн судалгаанд үндэслэн багш, суралцагчийн хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зохицуулалт хийнэ. | Холбогдох чиглэлээр гарсан шийдвэрийн тоо | - | Мэдээлэлд үндэслэн урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хийсэн байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Багш нарын эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлж, эрүүл мэндийн өнөөгийн байдалд үнэлэлт өгч, Багш багцын урьдчилан сэргийлэх үзлэг оношилгооны төрлийг тогтоох зорилгоор Багшийн эрүүл мэндийн тандалт асуумж судалгааг цэцэрлэг, ЕБС-ийн багш нараас авч, судалгааны дүнг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Багшийн эрүүл мэндийн талаар авах зарим авах арга хэмжээний тухай" 2022 оны А/238, А/340 дүгээр тушаал батлагдан хэрэгжиж байна.<br>Сургуулийн өмнөх боловсролын нийт 10470 багш, туслах багш нар хамрагдвал зохих үзлэг, оношилгоонд үнэ төлбөргүйгээр хамрагдсан байна. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотойгоор сургууль, цэцэрлэгт зориулсан Корона вируст халдварын эсрэг эрүүл мэндээ хамгаалах зөвлөмж боловсруулж холбогдох газруудад болон цахимаар олон нийтэд түгээсэн. Халдвар хамгаалал баримтлах талаар мэдээлэл сурталчилгааны зурагт хуудас, материалыг сургуулиудад тараасан. | |
| 16. | МУТЖҮЧ-2.2.1 Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эрсдэлийн үнэлгээ хийж нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулахад ашиглана. | Эрсдэлийн үнэлгээний тайлан | - | Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эрсдэлийн үнэлгээг хийж тайланг холбогдох газруудад танилцуулсан байна. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор түргэвчилсэн үнэлгээг 2022 оны 11 дүгээр сард УОК-ын Нэгдсэн шуурхай штабын оператив бүлэг, ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ зэрэг 9 байгууллагын мэргэжилтнүүд оролцон хийж “Дунд” зэргийн эрсдэлтэй гэж дүгнэн 7 чиглэлийн зөвлөмж гарган хэрэгжүүлж ажиллаж байна.<br>ОУЭМД (2005)-ийн дагуу “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал” хэмээн зарласан сармагчны цэцэг (МРОХ) өвчний эрсдэлийн үнэлгээг 2 удаа хийсэн.<br>- 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдөр ЭМЯ, ХӨСҮТ, ГЕГ, ЗӨСҮТ, НЭМҮТ, ДЭМБ-ын 28 хүний бүрэлдэхүүнтэй баг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээ хийхэд "Өндөр" эрсдэлтэй гэж үнэлж, 10 чиглэлийн зөвлөмж гаргалаа.<br>- 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдөр ЭМЯ, ХӨСҮТ, ГЕГ, ЗӨСҮТ, НЭМҮТ, ДЭМБ-ын 28 хүний бүрэлдэхүүнтэй баг давтан эрсдэлийн үнэлгээг түргэвчилсэн байдлаар хийхэд "Дунд" зэргийн эрсдэлтэй гарч, 4 чиглэлийн зөвлөмж гарган хэрэгжүүлж байна.<br>Нутагшмал бус улс, оронд бүртгэгдсэн сармагчны цэцэг өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ТНБД-аар батлуулан төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хүргүүлсэн.<br>ОУЭМД-ийн дагуу мэдээлсэн зарим цочмог өвчин (сармагчны цэцэг өвчин болон бага насны хүүхдийн дунд шалтгаан тодорхойгүй, цочмог, хүнд явцтай гепатит)-ний тохиолдол зөөвөрлөгдөн орж ирэх, дэгдэлт гарахаас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар албан даалгаврыг аймаг, нийслэлийн ЭМГ, НЭ, БОЭТ, ХӨСҮТ, | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ЗӨСҮТ, НЭМҮТ, ЭСҮТ-д 2022 оны 6/2766, 6/2767 дугаар албан бичгээр хүргүүлж, биелэлтийг ханган ажилласан. | |
| 17. | МУТЖҮЧ-2.2.2 Хүн амыг зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний тоо | - | Халдварт бус өвчнийг эрт илрүүлэг үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дугаар тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн сангийн 5781 дугаарт бүртгүүлсэн.<br>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд улсын хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 707,776 иргэн хамрагдсанаас 45.8 хувь нь эрэгтэйчүүд, 54.2 хувь нь эмэгтэйчүүд (Улаанбаатар хотод 354,596 буюу 50.1 хувь нь, орон нутагт 353,180 буюу 49.9 хувь) байна.<br>Нийт үзлэгт хамрагдсан иргэдээс 390,925 өвчлөлийн тохиолдол бүртгэгдсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Эдгээрийн 64.9 хувь нь хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, 9.1 хувь нь дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өөрчлөлт, 6 хувь нь шээс бэлгийн замын тогтолцооны өвчин, 5.8 хувь нь зүрх судас, 4.2 хувь нь амьсгалын тогтолцооны өвчлөл бүртгэгдсэн байна. | |
| 18. | ЗГҮАХ 1.1.3.1 КОВИД-19 цар тахлын халдвартай тэмцэх хариу арга хэмжээнд олон улсын дэмжлэг, туслалцаа авах, эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлнэ. | Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ | - | Салбарын хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг гадаад эх үүсвэрээс нэмэгдүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс дараах байдлаар бүрдүүлсэн:<br>1. АХБ-ны санхүүжилтээр 50,2 сая төгрөгийн үнэ бүхий 3,200 ширхэг моксифлоксациныг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>2. Япон Улсын Засгийн газрын санхүүжилтээр:<br>- 1,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг унтуулгын аппарат болон дагалдах хэрэгслийг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан<br>- 17,0 сая төгрөгийн үнэ бүхий 6 ширхэг эмнэлгийн зориулалт бүхий хөргөгч, 57,0 сая төгрөгийн үнэ бүхий эм болон эмнэлгийн хэрэгслийг хүлээн авсан.<br>- 1,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий эх, нярайн тусламж | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үйлчилгээнд ашиглах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөв.<br>- 595,9 сая төгрөгийн үнэ бүхий явуулын эмнэлэгт суурилуулах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч эмнэлгүүдэд хуваарилсан.<br>- 3,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг С хэлбэрт рентген аппаратыг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.<br>- 145,5 сая төгрөгийн үнэ бүхий 2 генийн дараалал тогтоогч 9,8 сая төгрөгийн үнэ бүхий генийн дараалал тогтоох шинжилгээний өгөгдлийг унших 2 зөөврийн компьютер, тог баригч, 207,0 сая төгрөгийн үнэ бүхий урвалжуудыг хүлээн авч УНТЭ болон ЗӨСҮТ-д тус тус хуваарилан өгсөн.<br>- 1,2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 548 ширхэг зөөврийн компьютер болон дагалдах хэрэгслийг хүлээн авч улсын хэмжээнддархлаажуулалтын цэгүүдэд хуваарилан өгсөн.<br>- 33,2 сая төгрөгийн үнэ бүхий 42 ширхэг пульсоксиметрыг хүлээн авч холбогдох эрүүл | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>- 2,1 тэрбум төгрөгийн үнэ бүхий 200,000 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч, нөөцөд авах тухай тушаалыг батлуулсан.<br>- 1,2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг уушгины дуран, 3 ширхэг уушгины мэс заслын багаж хэрэгслийн багцыг хүлээн авч ХӨСҮТ-д хуваарилан олгосон.<br>- 536,3 сая төг-ийн үнэ бүхий 3 явуулын эмнэлэг, ариун цэврийн байгууламжийн чингэлэг, 908,4 сая төг-ийн үнэ бүхий 3 явуулын эмнэлгийг хүлээн авч, эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахыг хариуцаж байгаа ЗӨСҮТ-д Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилан олгов.<br>- 449,5 сая төг-ийн үнэ бүхий 150,000 ширхэг аюулгүй хайрцгийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/430 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгуулагуудад хуваарилан олгов.<br>- 434,8 сая төгрөгийн үнэ бүхий 60 ш зөөврийн хөлдөөгчийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/433 дугаар тушаалаар хуваарилан олгов. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - 1,3 тэрбум төг-ийн үнэ бүхий 2 ширхэг барокамерыг хүлээн авч ХӨСҮТ, ГССҮТ-ийн Түлэнхийн төвд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/391 дүгээр тушаалаар хуваарилан олгов<br>- 221,5 сая төг-ийн үнэ бүхий 1 ширхэг вакцин тээвэрлэх зориулалт бүхий 1 ширхэг автомашиныг хүлээн авч, ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны хэрэгцээнд зориулж Эрүүл мэндийн сайдын А/419 дүгээр тушаалаар хуваарилан олгов<br>- 5,3 тэрбум төг-ийн 500,100 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч, эмнэлгүүдэд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/556 дугаар тушаалаар хуваарилан олгов.<br>- 738,2 сая төг-ийн үнэ бүхий 12 ширхэг С хэлбэрт рентген аппаратын тог баригчийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/327 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов.<br>- КОВАКС механизмын хүрээнд SARS-CoV-2 халдварын эсрэг 1,030,000 тун 5-11 насны хүүхдийн 302,400 тун хүлээн авсан.<br>3. НҮБ-ын Хүүхдийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сангийн буцалтгүй тусламжийн хүрээнд:<br>- 85,9 сая төгрөгийн үнэ бүхий 6,000 ширхэг нэг удаагийн халатыг хүлээн авч нөөцөд авсан.<br>- 862,3 сая төгрөгийн үнэ бүхий 787,500 ширхэг дексаметазон тариаг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>- 356,9 сая төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслүүдийг хүлээн авч нөөцөд авсан.<br>- 650,3 сая төг-ийн үнэ бүхий 32,500 ширхэг FFP2/N95 нарийн шүүлтүүрт амны хаалт болон 13,000 хайрцаг буюу 1,3 сая ш нэг удаагийн бээлийг хүлээн авч нөөцөд авсан.<br>- 1,9 тэрбум төг-ийн үнэ бүхий 199,997 ширхэг хамгаалалтын нүдний шилийг хүлээн авч Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/454 дүгээр тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгов<br>- 173,5 сая төг-ийн үнэ бүхий 120 ширхэг пульсоксиметр, 160 ширхэг зайнаас халуун хэмжигчийг хүлээн авсан.<br>- 20,000 ширхэг нэг удаагийн хамгаалалтын хувцасны иж | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүрдэл, 100,000 ш нэг удаагийн халад болон 20,000 ш нүүрний хаалтыг хүлээн авч ЭМЯ-ны нөөцөд авав.<br>- 113,7 сая төг-ийн үнэ бүхий 1,038 хайрцаг моксифлоксацин тариаг 10 дугаар сард хүлээн авч, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нөөцөд авав<br>- 981,1 сая төг-ийн үнэ бүхий 30,000 ширхэг нүүрний хаалт болон 30,000 ширхэг хамгаалалтын комбинезон 12 дугаар сард хүлээн авав. | |
| 19. | Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр эрүүл мэндийн байгууллагуудыг орчин үеийн эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангана. | Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо | - | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | Мэс заслын үед хэрэглэх 3,8 сая төг-ийн С хэлбэрт зөөврийн рентген аппарат 12 ш, 738,2 сая төг-ийн үнэ бүхий 12 ш С хэлбэрт рентген аппаратын тог баригч, 1,8 сая төг-ийн үнэ бүхий Мэс заслын унтуулгын аппарат 10 ш, 1,2 тэрбум төг-ийн үнэ бүхий Бронхоскопи 5 иж бүрдэл, Уушигны мэс заслын багажний сет 3 иж бүрдэл, 145,5 сая төг-ийн үнэ бүхий Бүрэн геномын шинжилгээ хийх сийквэнсэр 2 иж бүрдэл, 1,3 тэрбум төг-ийн үнэ бүхий 2 ш барокамерыг Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хүлээн авч аймаг, дүүрэг, ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудад | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуваарилсан.<br>Япон Улсын ЗГ-аас буцалтгүй тусламжийн хүрээнд дархлаажуулалтын бүртгэл мэдээллийг сайжруулах зорилгоор олгосон 1,2 тэрбум төг-ийн үнэ бүхий нийт 548 ш лаптоп зөөврийн компьютерийг 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн дархлаажуулалтын байнгын цэгүүдэд олгов.<br>Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБХС-аар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 1,8 тэрбум төг-ийн үнэ бүхий эх, нярайн тусламж үйлчилгээнд ашиглагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон.<br>Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБХС-аар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөр болон НҮБХС-ын “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй ба хөгжил” хөтөлбөрийн хүрээнд | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | МУ-ын ЗГ-т олгосон 6 явуулын эмнэлэг хүлээн авсан ба эмнэлэг бүрт зориулалтын хөргөгч, эмийн багц, дефибрилятор, хяналтын монитор, зөөврийн ЭХО, амьсгалын аппарат, ор, пульсоксиметр, дуслын болон тариурын автомат шахуурга, хүчилтөрөгч өтгөрүүлэгч суурилуулсан болно.<br>Япон Улсын Засгийн газрын "КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 221,5 сая төг-ийн үнэ бүхий 1 ш вакцин тээвэрлэх тусгай хөргүүр бүхий зориулалтын суудлын жип автомашиныг хүлээн авч ХӨСҮТ-д хуваарилса. | |
| ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| 2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | | |
| 20. | ЗГҮАХ 2.1.1.1<br>МУТЖҮЧ-2.2.1<br>"Эрүүл, идэвхитэй амьдрал" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2021 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан | Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар "Эрүүл идэвхтэй амьдрал" 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар 2022 оны 2/387 тоот албан бичгээр арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг холбогдох | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагуудад хүргүүлсэн. Арга хэмжээний хэрэгжилт 38%-тай байна. | |
| 21. | ЗГҮАХ 2.1.1.2 МУТЖҮЧ-2.2.1 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний төслийг боловсруулж байна. | Арга хэмжээний хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХӨХ | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж ажлын хэсгийн 9 удаагийн хурлыг зохион байгуулж, төлөвлөгөөний төслийг ЭМЯ-ны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 30 |
| 22. | ЗГҮАХ 2.1.1.3 МУТЖҮЧ-2.2.2 МУХТ 2.1.19 "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2021 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан | Арга хэмжээний хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2022 оны 2/387 тоот албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>Төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтийн биелэлт 55 хувьтай байна. | 100 |
| 23. | ЗГҮАХ 2.1.1.4 МУТЖҮЧ-2.2.2 МУХТ 2.1.20 "Хавдрын эсрэг" арга хэмжээг эхлүүлж, хүн | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хувь | 2021 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтыг 50 хувьд хүргэсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах чиглэлийг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 2/387 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>Арга хэмжээний төлөвлөгөөний | 50 (48) |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулна. | | | | | | явцыг танилцуулах уулзалтыг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр цахимаар зохион байгуулж, уулзалтад 21 аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн 200 гаруй удирдах ажилтнууд, эмч мэргэжилтнүүд оролцсон. 2022 оны 6/4220 тоот албан бичгээр Хавдрын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг IV улиралд эрчимжүүлж ажиллах чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт 18.6 хувьтай байна. | |
| 24. | УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1 ЗГҮАХ 2.1.1.5 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна. | ЗГ-ынтогтоол, арга хэмжээний хэрэгжилтийн хувь | “Элэг бүтэн Монгол” эхний хөтөлбөр хэрэгжиж дууссан. | Арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, ЗГ-ын тогтоолоор батлуулсан байна Арга хэмжээний хэрэгжилт 40-50%-д хүрсэн байна. | I-II улирал | ЭТҮГ-АЛШТХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 629 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 17 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж, “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-г баталсан. | 30 |
| 25. | ЗГҮАХ 2.1.1.6 МУТЖҮЧ-2.2.2 МУХТ 2.1.22 | | 2021 онд Эрүүл мэндийн | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн | IV улирал | НЭМГ-ХБӨХ | Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | сайдын тушаалаар батлагдсан | байна. | | | ажиллах чиглэлийг 2022 оны 2/387 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан. Арга хэмжээний төлөвлөгөөний явцыг танилцуулах уулзалтыг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр цахимаар зохион байгуулж, уулзалтад 21 аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн 200 гаруй удирдах ажилтнууд, эмч мэргэжилтнүүд оролцсон. 2022 оны 6/4220 тоот албан бичгээр Харшлаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг IV улиралд эрчимжүүлж ажиллах чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 56.0 хувьтай байна. | 90 (80) |
| 26. | ЗГҮАХ 2.1.1.7 МУТЖҮЧ-2.2.2 “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлнэ. | | 2021 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан | Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | I-IV улирал | НЭМГ-ХБӨХ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар батлагдсан “Эрүүл чийрэг эр хүн” 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг 2022 оны 2/387 тоот албан бичгээр арга хэмжээний холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааны хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна.<br><br>- “Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо” арга хэмжээний хүрээнд “Эрэгтэйчүүдийн үнэт зүйлс, үлгэр дуурайлал” сэдэвт ажлыг Эрүүл мэндийн яамны харьяа 36 байгууллагыг хамруулан зохион байгуулсан.<br>- ЭХЭМҮТ-д 2022 оны эхний улирлын байдлаар нийт 40 үргүйдэлтэй эрэгтэйд мэс засал хийж эр бэлгийн эсийг авч үргүйдлийн эмчилгээнд хэрэглэснээр 18 эмэгтэй жирэмсэлж, эсэн мэнд амаржсан байна.<br>- АШУҮИС-д хийгдэж байгаа “Үр хөврөлийн удамзүйн оношилгоо ба эр бэлгийн эсийн хөгжлийн эхэн үеийн эсийг үр тогтоох эмчилгээнд ашиглах технологийг нэвтрүүлэх нь” судалгааны ажлын хүрээнд эрэгтэй шалтгаант үргүйдэлтэй 7 эрэгтэй үйлчлүүлэгчид эр бэлгийн эс авах мэс засал эмчилгээ хийж 6 (86%) үйлчлүүлэгчээс эр бэлгийн эс авч 2 тохиолдолд жирэмсэлсэн. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Эрчүүдээ эрүүл мэндээ анхаарцгаая! цуврал 9 төрлийн инфографикийг цахим хуудсанд байршуулсан.Төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьтай байна. | |
| 27. | МУТЖҮЧ-2.2.2 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын шүдний кабинетын тоног төхөөрөмжийн ашиглалт, хүний нөөцийн бэлэн байдал, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, кабинетын үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Шаардлагатай тоног төхөөрөмж өөр үе шаттай хангаж, хүний нөөцийг бэлтгэж эхэлсэн. | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын шүдний кабинетын үйл ажиллагааны бэлэн байдлын үнэлгээ хийгдсэн байна. | II-III улирал | НЭМГ-УСХЗХ | Нийслэл, болон орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн төвийн шүдний кабинетийн үйл ажиллагааг үнэлэх удирдамж боловсруулж, 2022 оны 05 сарын 10-ны өдөр ТНБД-аар батлуулсан. Үнэлгээний асуумжийг 2022 оны 2/253 тоот албан бичгээр аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлж, ирүүлсэн мэдээллийг үндэслэн тайлан гаргасан. | 30 |
| 28. | ЗГҮАХ 2.1.2.2 Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна. | Эмчилгээнд хамрагдсан хувь | - | Эмчилгээнд хамрагдах хувийг 30 хувьд хүргэнэ. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Элэгний Дельта вирусийн Буливертайд эмийг 12 өвчтөн хэрэглэж байгаа ба мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон аймаг нийслэлийн ЭМГ-ын дотрын эмч нарыг мэргэжлийн арга зүйгээр ханган, олон улсын удирдамжийн дагуу ажиллаж байна. Буливертайд эмийг 2021 оны А/347 дугаар тушаалаар 2 жилийн хугацаагаар өнчин эмийн жагсаалтад оруулснаар | 0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | уг эмийг импортлон эмчилгээнд хэрэглэх нөхцөл бүрдсэн. Гилеад Сайенс компанитай 3 удаагийн уулзалт зохион байгуулж, дээрх эмийг Европын зах зээлд борлуулагдаж буй үнийн дүнгээс 70-80%-ийн хөнгөлттэй үнээр манай улсад нийлүүлэхээр урьдчилсан байдлаар зөвшилцсөн. | |
| 29. | ЗГҮАХ 2.1.3.2 Зүрх судасны төв байгуулж, үндэсний баг бүрдүүлнэ. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | Барилгын ажлын явц 50 хувьд хүрсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Зүрх судасны төв байгуулах зураг төсвийг Люксембургийн 1,5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хүрээнд хийж магадлалаар баталгаажуулсан. 2022 онд ЗСҮТөвийн барилгын техникийн 5 нөхцлийг шинэчилсэн. Барилгын төсвийг 2022 онд дахин шинэчлэн хийлгүүлсэн ба барилгын төслийг Засгийн газар, гадны хөрөнгө оруулагчдад танилцуулж, хөрөнгө оруулалт татах/босгох чиглэлээр ажиллаж байна. УИХ-ын гишүүд, Үндэсний аюулгүй байдлын газар, Ерөнхийлөгчийн тамгын газар, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Люксембургийн их гүнт улсын Хамтын ажиллагаа хүмүүнлэгийн сайд бөгөөд Эдийн засгийн сайд, Европын хөрөнгө оруулалтын банк, Европын хөрөнгө оруулалтын | 0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | банк, Барилгын санхүү, ТЭЗҮ, урьдчилсан үнэлгээ (шаардлагатай тохиолдолд) нэмэлт санхүүжилтээр хийлгэхээр зөвшилцсөн. Мөн Япон Улсын Tokushukai medical corporation –ийн ерөнхийлөгч, төлөөлөгчдөд танилцуулж барилгын тодорхой хувийг санхүүжүүлэхээр болсон байна. | |
| 30. | ЗГҮАХ 2.1.3.3 Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | Барилгын ажлын явц 60 хувьтай байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил Засгийн газрын тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж, “Хар чонот” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж иргүүлсэн.<br>Тус компани нь Сангийн сайдын 2021 оны тушаалаар “хар жагсаалт” буюу тендерт оролцох эрхгүй ААНБ-ын жагсаалтад орсон тул гэрээ байгуулах боломжгүй тухай албан бичгийг ТХААГ-т хүргүүлсэн.<br>Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг дахин зарласан боловч “Хар чонот” ХХК шүүхэд гомдол гаргасан тул түр зогссон. Шүүхийн шийдвэр хүлээгдэж байна.<br>Зураг төсөл, ТЭЗҮ | 0 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулалт - 100% Барилгын ажил эхлээгүй. | |
| 31. | ЗГҮАХ 2.1.3.4 Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | Барилгыг ашиглалтад оруулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс эрүүл мэндийн салбарт Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй байна. Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн тул төсөвт өртгийн нэмэгдлийг Сангийн яаманд 2020-2022 онуудын төсвийн тухай хуульд тусгуулахаар өргөн барьсан боловч төсөвт өртөг нэмэгдэж батлагдаагүй. | 30 |
| 32. | ЗГҮАХ 2.1.3.5 Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | Барилгыг ашиглалтад оруулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | ГССҮТ-ийн харьяа Түлэнхийн төвийн барилга нь А, Б блокоос бүрдэж байгаа бөгөөд Эрүүл мэндийн яам, “Цаст констракшн” ХХК-ны хооронд байгуулсан гэрээний дагуу “А” блокийн барилга байгууламжийг улсын комиссын шийдвэрээр хэсэгчилсэн байдлаар ашиглалтад оруулан, 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаа эхлүүлсэн. Эрүүл мэндийн яам, “Нутгийн | 90 (95) |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зам групп" ХХК-ны хооронд байгуулагдсан гэрээний дагуу "Б" блокийн барилгын ажил гүйцэтгэх тоо хэмжээнд багтсан ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Нийт барилга угсралтын ажлын гэрээнд дулааны узель, гадна тохижилт, хашааны ажил, зоорийн давхрын нэмэлт өөрчлөлтийн ажлын тоо хэмжээ багтаагүй байсан нь төслийг хугацаандаа дуусгах боломжгүй болсон бөгөөд Арабын Эдийн Засгийн Хөгжлийн Кувейтийн сангаас ирүүлсэн бичгийг үндэслэн Эрүүл мэндийн яам, "Нутгийн зам групп" ХХК-тай барилга угсралтын ажлын гэрээнд тусгагдаагүй ажлыг хийж гүйцэтгүүлэхээр тухайн үеийн магадлагдсан төсвийн үнэлгээгээр 672,579.52 ам.доллар буюу 2,3 тэрбум төгрөгийн нэмэлт ажлын гэрээг байгуулаад байна. 2023 оны 3 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Барилгын гүйцэтгэл 95 хувь | |
| 33. | ЗГҮАХ 2.1.3.6 Халдварт өвчин | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | Цогцолбор баригдаж эхэлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Нийслэлийн дахин төлөвлөлт буюу шинэ суурьшлын бүс Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг ХӨСҮТ-д шилжүүлэн гэрчилгээг олгосон. Халдварт өвчин судлалын үндэсний төв II | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | судлалын үндэсний тевийн цогцолбор салбар II байгуулна. | | | | | | барих зураг төслийг батлуулсан бөгөөд 2023 оны төсвийн төсөлд тусгах саналыг хүргүүлсэн боловч 2023 онд шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөв батлагдаагүй. | 30 |
| 34. | ЗГҮАХ 2.1.3.7 Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна. | Барилгын гүйцэтгэлийн хувь | - | Барилгын ажлын явц 10 хувьд хүрсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Нийслэлийн дахин төлөвлөлт буюу шинэ суурьшлын бүсэд Хавдар судлалын үндэсний төв II барих зураг төслийг батлуулсан бөгөөд 2023 оны төсвийн төсөлд тусгах саналыг хүргүүлсэн боловч 2023 онд шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөв батлагдаагүй. | 0 |
| 35. | ЗГҮАХ 2.1.3.8 Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барьна. | Зураг төсөв, ТЭЗҮ | - | Зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Барилга, хот байгуулалтын сайдын багцад 268,9 сая төгрөгийн төсөвт өртөг тусгагдсан бөгөөд зураг төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, "Татах хүч" ХХК-тай гэрээ байгуулан зураг төсөв хийгдэж байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м2 газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж, мөн зураг төсвийн ажил хүлээгдэж байна. Барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэхээр | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслүүдэд санал хүргүүлсэн. | |
| 36. | ЗГҮАХ 2.1.12.3<br>ЗГҮАХ 2.1.12.4<br>Эрүүл мэндийн салбарын шилжих 45 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. /МУ-ын2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.1.1-XIX.1.45/ | Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь<br><br>Санхүүжилтийн мөнгөн дүн | Барилга угсралтын ажил эхлээгүй 1 төсөл, арга хэмжээ, бусад барилгуудын ажлын явц 20-25% гүйцэтгэлтэй байна. | Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэн, барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Шилжих нийт 45 төсөл, арга хэмжээнээс 13 төсөл, арга хэмжээ орон нутагт эрх шилжин санхүүжилт олгогдож байна.<br>Мөн Эрүүл мэндийн яамнаас санхүүжилт шийдвэрлэгдэж байгаа 32 төсөл, арга хэмжээний 31.0 тэрбум төгрөгнөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 24.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгоод байна.<br>Оны эцэст 2022 онд санхүүжих 31.0 тэрбум төгрөгийг бүрэн олгох бөгөөд 11 төсөл, арга хэмжээний 6.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл Барилгын хөгжлийн төвд хянагдаж байна. */Эрүүл мэндийн сайдын багц 45 төсөл, арга хэмжээ 38.5 тэрбум төгрөгөөс 32.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон/* | 90 |
| 37. | ЗГҮАХ 2.1.12.3<br>ЗГҮАХ 2.1.12.4<br>Эрүүл мэндийн салбарын шинэ 36 төсөл, арга хэмжээг | Барилгын угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | Шинэ барилгуудын ажлын даалгаврыг | Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэн, барилга угсралтын ажлыг | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Шинэ 36 төсөл, арга хэмжээнээс 14 төсөл, арга хэмжээ орон нутагт эрх шилжин санхүүжилт олгогдож байна.<br>Мөн Эрүүл мэндийн яамнаас | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | батлагдсан төсвийн хүрээнд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. МУ-ын2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.1.46-XIX.1.81/ | | боловсруулж байна. | дунджаар 20%д хүргэх, тухайн оны санхүүжилтийг гүйцэтгэлээр бүрэн авна. | | | шийдвэрлэгдэж буй шинэ 22 төсөл, арга хэмжээний 10.4 тэрбум төгрөгнөөс 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 6.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгоод байна.<br>Оны эцэст 2022 онд санхүүжих 10.4 тэрбум төгрөгийг бүрэн олгох бөгөөд 8 төсөл, арга хэмжээний 4.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл Барилгын хөгжлийн төвд хянагдаж байна. */Эрүүл мэндийн сайдын багц 36 төсөл, арга хэмжээ 19.3 тэрбум төгрөгөөс 14.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон/* | |
| 38. | Эрүүл мэндийн салбарын шилжих 2 их засварын төсөл, арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд үлдэгдэл санхүүжилтийг олгоно. МУ-ын2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.2.1-XIX.2.2/ | Засварын гүйцэтгэлийн хувь | Засварын ажлын явц 60%тай байна. | Засварын ажил 100% гүйцэтгэлтэй байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Аймгийн нэгдсэн эмнэлгийн цахилгаан шат /Увс, Улаангом сум/, Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, шаамар сум/ төсөл, арга хэмжээний 210 сая төгрөгийн санхүүжилт буюу 100 хувийн санхүүжилтийг олгоод байна. | 70 (67.5) |
| 39. | Эрүүл мэндийн салбарын шинэ 5 их засварын төсөл, арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд гэрээ байгуулан | Засварын гүйцэтгэлийн хувь | Засварын ажлын зураг төсвийн ажлын даалгавар | Засварын ажил 100% гүйцэтгэлтэй байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | - XIX.2.3 БОЭТ-ийн цахилгаан шатны шинэчлэл /Дорнод, Хэрлэн сум/ 2022 оны санхүүжилт 100 хувь,<br>- XIX.2.4 Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжилтийг олгоно. МУ-ын2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.2.3-XIX.2.7/ | | ыг боловсруулж байна. | | | | засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ 2022 оны санхүүжилт 100 хувь,<br>- XIX.2.5 Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ 2022 оны санхүүжилт 70 хувь,<br>- XIX.2.6 ЭХЭМҮТ-ийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ 2022 оны санхүүжилт 100 хувь,<br>- XIX.2.7 ХӨСҮТ-ийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ 2022 оны санхүүжилт 100 хувь,<br>Нийт их засварын ажлын явц 94 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 3,018.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | 90 (94) |
| 40. | Эрүүл мэндийн салбарын шилжих 6 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд үлдэгдэл санхүүжилтийг олгоно. МУ-ын2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.3.1-XIX.3.6/ | Тоног төхөөрөмжийн хангалтын гүйцэтгэлийн хувь | 7 төсөл арга, хэмжээний гүйцэтгэл 95%-тай байна. | Тоног төхөөрөмжийн хангалт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Эрүүл мэндийн салбарын шилжих 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний 2022 онд санхүүжүүлэх 1.9 төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгоод байна. Тоног төхөөрөмжийн хангалт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| 41. | Эрүүл мэндийн салбарын шинэ 24 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг гэрээ байгуулан, | Тоног төхөөрөмжийн хангалтын гүйцэтгэлийн | Төсөл, арга хэмжээнүүдийн хөрөнгө | Эрүүл мэндийн салбарын шинэ 22 тоног төхөөрөмжийн төсөл, арга | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Шинээр нийт 17.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 5.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 24 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаа | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүжилтийг олгоно. МУ-ын2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIX.3.7-XIX.3.30/ | хувь | оруулалтын жагсаалт, техникийн үзүүлэлтийг боловсруулж байна. | хэмжээг гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон байна. | | | зохион байгуулагдаж 100 хувь гэрээ байгуулсан. /1.4 *тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон/* | |
| 42. | ЗГҮАХ 2.1.3.10 Гадаадын зээл, тусламжийн хүрээнд эрүүл мэндийн салбарт цөмийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | Стереотактик туяа эмчилгээний сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | - | Стереотактик туяа эмчилгээний сургалтад эмч, техникч, эмнэлгийн физикчдийг хамруулсан байна. | I-IV улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/276, А/533 дугаар тушаалаар хавдрын туяа эмчилгээгээр 3 эмч, хавдрын хими эмчилгээгээр 11 эмч, компьютер томографи/ рентген туяаны 9 техникчийг элсүүлэн сургаж байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/302, А/343, А/572 дугаар тушаалаар хавдрын туяа эмчилгээ судлалаар 2 эмч, хавдрын хими эмчилгээ судлалаар 11 эмч, компьютер томографи/рентген туяаны техникч 4 төгсөж, төрөлжсөн мэргэшил эзэмшсэн. | 100 |
| 43. | ЗГҮАХ 2.1.3.11 Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | Батлагдсан зураг төсөл | - | Батлагдсан зураг төслийн дагуу холболт хийнэ. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 100 ортой нэгдсэн эмнэлэг, 30 ортой Сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг боловсруулан Барилгын хөгжлийн төвийн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулж, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 44. | ЗГҮАХ 2.1.4.1 МУТЖҮЧ-2.2.4 Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна. | Үйл ажиллагаа нь эхэлсэн яаралтай тусламжийн цэг | - | Орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулагдсан байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг өндөр, Архангай аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийг хуваарилсан. Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна. | 90 |
| 45. | | Яаралтай тусламжийн | - | Эрүүл мэндийн байгууллагуудыг | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗГҮАХ 2.1.4.2 ТЭМТББ 2.4.5.4 Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана. | техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн лавлагаа шатлалын эмнэлгийн тоо | | яаралтай тусламжийн техник, тоног төхөөрөмжөөр хангасан байна. | | | ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон ХӨСҮТ, УХТЭ, ЗӨСҮТ, ЭСҮТ, ЭМХТ, УГТЭ-т нийт 4,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгосон. Түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгосон. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт Хөгжлийн төлөвлөлтийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд "Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II"-ийн коронавируст халдвар (КОВИД-19)-ыг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашин олгосон. ОХУ-ын Москва хотноо тус улсын Эрүүлийг хамгаалах яамны харьяа Хүүхдийн анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний төвд "Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зарчмууд" сэдэвт сургалтад ЭХЭМҮТ, Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө амаржих | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газраас нийт 15 эмч нарыг сургалтад хамруулсан. | |
| 46. | ЗГҮАХ 2.1.4.3 Яаралтай тусламж үйлчилгээнд агаарын үйлчилгээг (нисдэг тэрэг) нэвтрүүлнэ. | Батлагдсан шийдвэр | - | Яаралтай тусламжид нисдэг тэрэг нэвтрүүлж үйлчилгээг төр хувийн хэвшлийн гэрээний үндсэн дээр үзүүлж эхэлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах" төслийн III үе шат буюу 2026 онд энэхүү төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд судалгааны ажил хийгдэж байна.<br>Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээнд ОБЕГ, хувийн хэвшлийн байгууллагатай иргэд хувиараа хамтран ажиллаж нисдэг тэргээр тусламж, үйлчилгээ авч байгаа ч үйлчилгээг төр, хувийн хэвшлийн гэрээний үндсэн дээр үзүүлж эхлээгүй байна. | 0 |
| 47. | ЗГҮАХ 2.1.4.4 Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ. | Шинээр олгосон түргэнтусламжийнавтомашины тоо | | 100 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | 2022 онд 21 аймаг, лавлагаа шатлалын 50 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна. | 50 |
| 48. | | Эрүүл мэндийг дэмжих төвийг шинээр байгуулсан эмнэлгийн | - | 2 дүүрэг, 5 эмнэлэгт Эрүүл мэндийг дэмжих төв байгуулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг 17 аймаг (Архангай, Орхон, Төв, Баянхонгор, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Хархорин, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Дорноговь | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ЗГҮАХ 2.1.5.1 Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулна. | тоо | | | | | аймгийн Замын Үүд, Сэлэнгэ, Булган, Увс, Завхан, Дорнод), 3 дүүргийн Эрүүл мэндийн төв (Баянзүрх, Багануур, Сонгинохайрхан), төрөлжсөн мэргэшлийн 3 эмнэлэг (УГТЭ, УХТЭ, УНТЭ)-т байгуулж нийт 1.2 тэрбум төгрөгийн өртөгтэй, 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр хангасан. Нийт 12.1 тэрбум төгрийн санхүүжилтийг зарцуулсан байна.<br>Увс, Завхан Булган, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Баян-Өлгий, Хөвсгөл, Сэлэнгэ зэрэг 9 аймагт 11.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Эрүүл мэндийг дэмжих төвийн засварын үйл ажиллагаа 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| 49. | ЗГҮАХ 2.1.5.2 МУХТЖҮЧ 2.2.1 МУ-ын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна. | ЗГ-ынтогтоол | - | ЗГ-ын тогтоолоор үндэсний товлолыг шинэчлэн батлуулсан байна. | III-IV улирал | НЭМГ-ХӨХ | Дархлаажуулалтын товлолд “Пневмококк, А вируст гепатит, Хүний папиллома вирусийн халдвар”-ын эсрэг вакциныг нэмэлтээр оруулахаар дархлаажуулалтын хуулийн төсөлд тусгасан. Дархлаажуулалтын хуульд нэмэлт оруулж батлуулсны дараа Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг Засгийн газрын | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоолоор шинэчлэн батлуулах юм. Бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг батлуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Дархлаажуулалтын зөвлөх хорооны хурлаар хэлэлцүүлэхээр 2022 оны 6/5172 албан тоотоор хүргүүлсэн. Хурал 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж, ЗГ-ын тогтоолын төслийг дэмжсэн. | |
| 50. | ЗГҮАХ 2.1.5.2 Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна. | Нэмэлт өөрчлөлт орсон хуулийн төсөл, үзэл баримтла-лын төсөл | - | Хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл Засгийн газраар хэлэлцүүлнэ. | II-IV улирал | НЭМГ-ХӨХ | Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, хуулийн төслийн танилцуулга, хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээг хийж, мэргэжлийн салбар зөвлөл, тусгай мэргэжлийн төвөөс санал авч, тусгасан. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ЭМЯ-ны https://moh.gov.mn/news/5669 цахим хуудсанд 1 сарын | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хугацаатай байршуулсан. Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж удирдлагын зөвлөлийн гишүүдийн саналыг тусган үзэл баримтлалыг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан. Хуулийн төсөлд 15 яамнаас санал авч тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг СЯ, ХЗДХЯ-аас авч ЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхээр дэмжигдсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар хуралдааны тэмдэглэлийг үндэслэн СЯ, ХЗДХЯ-аас УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл авахаар 2022 оны 1а/5434, 1а/5435 албан тоот хүргүүлсэн. | |
| 51. | ЗГҮАХ 2.1.5.3 Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | Мэдээлэл, сургалт, сурталчил-гаа, ухуулга нөлөөлөл, тандалт, судалгааны ажлын нэгдсэн тайлан | - | Мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Эрүүл мэндийг дэмжих сангийн төслийн сонгон шалгаруулах хурлыг 2022 оны 02 дугаар сарын 14, 05 дугаар сарын 23, 11 дүгээр сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 2022 оны 1,2,3 дугаар улиралд хэрэгжүүлэхээр сонгогдсон төслийн жагсаалтыг | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01, 03, 06 дугаар тушаалыг тус тус батлуулж, гүйцэтгэгч газруудтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр 47 төрийн бус байгууллага, 26 төрийн байгууллагууд нийт 2,7 тэрбум төг-ийн санхүүжилт авч эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан байна. | |
| 52. | ЗГҮАХ 2.1.5.4 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулна. | УИХ-аар хэлэлцүүлсэн хууль | Тусгайл-сан хууль байхгүй | Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна. | I-IV улирал | НЭМГ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/58 дугаар тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан.<br>Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах шийдвэр гарсны дагуу хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулж, хууль санаачлагчид хүргүүлэхэд бэлэн болсон. | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 53. | ЗГҮАХ 2.1.5.5 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчилнэ. | Шинээр батлагдсан дүрэм, стандартын тоо | - | Шаардлагатай дүрэм, стандартыг шинэчлэн батлуулсан байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартын төслийг эцэслэн боловсруулсан. Стандартын төслийг боловсруулахад 4 удаагийн ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан яамны цахим хуудсанд 1 сар байршуулан, аймаг, нийслэлийн ЭМГ, НЭМҮТ-өөс санал авсан. | 30 |
| 54. | ЗГҮАХ 2.1.5.6 Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна. | УИХ-р хэлэлцүүлсэн хууль | - | Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-р хэлэлцүүлсэн байна. | III улирал | БТГ-СУХ | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдаар батлуулсан. Хуулийн төсөл, хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, зардлын тооцоо, хууль дагалдан өөрчлөлт орох холбогдох хуулийн төслүүдийг боловсруулан бүх яамд, бусад холбогдох байгууллагуудаас санал авч 41 хувийг тусгасан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг ХЗДХЯ-аас авсан. СЯ-аас нэмэлт тодруулга шаардлагатай гэсний дагуу холбогдох тайлбарыг хийж, дахин зөвшөөрөл хүсэх тухай | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022 оны 1а/5133 тоот албан бичгээр хүргүүлсэн. Яамны Удирдлагын зөвлөлийн 2022.11.18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. | |
| 55. | ЗГҮАХ 2.1.5.7 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхийг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна. | ЗГ-ынтогтоол | - | 3 аймаг, 2 дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна. | II-IV улирал | БТГ-СУХ | НЭМТ байгуулах нөхцөл байдлыг судлах зорилгоор "Нийгмийн эрүүл мэндийн хэрэгцээ тодорхойлох судалгаа"-г Увс, Дорнод, Өмнөговь, Архангай, нийслэлийн 3 дүүрэгт "Халдварт бус өвчний хяналт, эмийн аюулгүй байдлыг боловсронгуй болгох нь" төслийн хүрээнд хийсэн. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн төвийг бие даалган байгуулахад барилга байгууламж, түүний ашиглалт, засвар, зарим тоног төхөөрөмж зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар 2022 оны 1А/3596 тоот албан бичгээр Аймаг, нийслэлийн засаг дарга нараас саналыг авсан. Нийт 11 аймаг, Нийслэлийн 3 дүүрэг 2023 онд бие даан байгуулах боломжтой гэсний дагуу үе шаттайгаар байгуулахаар "Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай" | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Засгийн газрын тогтоол болон дагалдаж гарах баримт бичгийн төслийг боловсруулсан. Асуудлыг Удирдлагын зөвлөлийн хурлаар 2022 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хэлэлцүүлсэн бөгөөд холбогдох тооцоог хийсний үндсэн дээр ЗГХЭГ-т хүргүүлэх шийдвэр гарсан. | |
| 135. | МУТЖҮЧ 2.2.2 Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн стратеги төлөвлөгөө (2022-2030) боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан. | Батлагдсан стратеги төлөвлөгөө, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Стратеги төлөвлөгөө батлагдаж, 2022 онд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн стратеги төлөвлөгөө (2022-2030)-ний төслийг боловсруулж, 21 аймаг, 9 дүүрэг, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-II, Өргөө, Хүрээ, Амгалан газруудын эмч, мэргэжилтнүүдийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэгт танилцуулан, саналыг авч тусгасан. | 30 |
| 136. | Сувилахуйн тусламж, үйлчилгээний стратеги төлөвлөгөө (2022-2026) боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулна. | Батлагдсан стратеги төлөвлөгөө, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Стратеги төлөвлөгөө батлагдаж, 2022 онд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Сувилахуйн тусламж, үйлчилгээний стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл, дотоод меморандумаар газар хэлтсээс саналыг авч нэгтгэн эцэслэн боловсруулсан. | 30 |
| 137. | МУТЖҮЧ-2.2.2, Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх журмыг шинэчилнэ. | Батлагдсан журам | - | Шинэчлэгдэн батлагдсан журмыг эрүүл мэндийн байгууллагуудад танилцуулсан байна. | I-II улирал | ЭТҮГ-АЛШТХ | “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай журам”-ыг боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/263 дугаар тушаалаар батлуулж, 5/2191 албан тоотоор эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. “Тогтвортой хөгжлийн зорилт ба хүүхдийн эрүүл мэнд үндэсний | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвлөгөөн"-д оролцогчдод танилцуулсан. | |
| 138. | ЗГҮАХ 2.1.13.2, МУТЖҮЧ-2.2 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ. | Иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлсэн өрх, сум, тосгоны ЭМТ-ийн эзлэх хувь | ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоол, ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолоор зохицуулж байна. | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоол, ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолыг нэгтгэн шинэчилж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлэх нөхцлийг бүрдүүлж ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолыг батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан оношийн хамааралтай бүлгийн журмаар зохицуулсан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын гэрээний шалгуур үзүүлэлтийг боловсруулан ЭМДҮЗ-ын 13 дугаар тогтоолоор батлуулахад санал өгч хамтарч ажилласан. Ингэснээр сар бүр нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80%-ийн урьдчилгаа санхүүжилтийг олгож, үлдсэн 20%-ийг гэрээний шалгуур үзүүлэлтээр хянаж олгох нөхцлийг бүрэн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүрдүүлсэн.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын цахим программ хөгжүүлэлтийн явцаас шалтгаалж ЭМДҮЗ-ийн 2022 оны 09, 14 дүгээр тогтоолуудаар нэг иргэний санхүүжилтийн сар бүрийн гүйцэтгэлээр хянаж олгох 20%, эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг сар бүрийн статистик тоонд үндэслэн 4-10 сарын санхүүжилтийг олгох асуудлыг тус тус шийдвэрлүүлсэн. | |
| 139. | Эмнэлзүйн зааврудыг шинэчлэн боловсруулж батлуулна. | Шинэчлэгдэн батлагдсан эмнэлзүйн зааврын тоо | - | Шинэчлэх шаардлагатай эмнэлзүйн зааврудыг боловсруулж батлуулсан байна. | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Эрүүл мэндийн сайдын нийт 12 тушаалаар 17 эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн заавар батлагдсан. Үүнд:<br>- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн түр заавар А/33,<br>- Амилойдозын оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар А/81,<br>- Бөөр шээсний замын халдварын оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар А/77,<br>- Бөөрний эмгэгийг оношлох бөөрний амьд сорьцын шинжилгээний эмнэлзүйн заавар А/78, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Бугуйн сувгийн хам шинжийн эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн заавар А/82,<br>- Тохойн сувгийн хамшинжийг оношлох эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн заавар А79,<br>- Гемодиализ эмчилгээний эмнэлзүйн заавар А/147,<br>- Өндөр давтамжит радио долгионоор шамбарам түлэх эмчилгээний эмнэлзүйн заавар А/80,<br>- Хүүхдийн нүдний угийн улаан рефлекс илрүүлэх заавар, хүүхдийн нүдний улаан рефлексийг үнэлэн ретинобластом хорт хавдрыг илрүүлэх заавар А/172,<br>- Нүдний даралт ихсэх өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар А/173,<br>- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дараах эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн ерөнхий заавар, А/435 | |
| 140. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартуудыг шинэчлэн боловсруулж батлуулна. | Стандарт хэмжил зүйн газраар батлуулахаар хүргүүлсэн стандартын тоо | - | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Стандартчлалын хороогоор хэлэлцүүлж, Стандарт хэмжилзүйн газар хүргүүлсэн байна | I-IV улирал | ЭТҮГ-АЛШТХ | Эрүүл мэндийн сайдын **А/221** дүгээр тушаалаар хавдар, арьс, эх барих, эмэгтэйчүүд, сувилахуй, уламжлалтын түгээмэл үйлдлийн стандартуудыг боловсруулах үндсэн болон дэд ажлын хэсгийг баталсан. | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Уг ажлын хэсэг шинэчлэн боловсруулах 724 түгээмэл үйлдлийн жагсаалтыг гарган эрүүл мэндийн байгууллагууд, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг холбоодоос санал авсан. Стандартын эхний төслийг боловсруулж дууссан. Стандартын төслүүдэд холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн байгууллагуудаас албан бичиг илгээн төсөлд санал авч байна. | |
| 141. | Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулна. | Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн баталсан шийдвэр | | Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдэн үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. | I улирал | ЭТҮГ-АЛШТХ | Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, журмыг Эрүүл мэндийн сайдын тушаал 2022 оны А/220 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. | 100 |
| 142. | Эмнэлгийн тусламжийн чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр 2022-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, сайдын тушаал батлагдсан байна. | I-II улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 136 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах” ажлын удирдамж, 2022-2025 онд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах ажлын төлөвлөгөөг 6 зорилт 31 арга хэмжээг тусган баталсан. | 100 |
| 143. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой алдаа, | Цахим мэдээний нэгдсэн санд | - | Цахим санг ашиглалтанд оруулж, | I-III улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ | Эрүүл мэндийн Мэдээллийн технологийн удирдах зөвлөлийн хорооны 2 удаагийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөрчил, эрсдлийн тохиолдлыг бүртгэх цахим мэдээний нэгдсэн санг өргөжүүлж шинэчилнэ. | мэдээлэл тогтмол оруулж, баяжилт хийдэг эрүүл мэндийн байгууллагын тоо | | эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой алдаа, зөрчил, эрсдлийн тохиолдлыг тогтмолж бүртгэж, баяжилт хийдэг болсон байна. | | | хурлаар “Тохиолдол бүртгэлийн нэгдсэн систем”-ийг хэлэлцүүлэн удирдах зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу зохих засварыг хийн гэрээ дүгнэн тус програм хангамжийг 2022 оны 6 сард хүлээж авсан. 2022 оны 12 сарын 8-ны байдлаар тус санд 36 эрүүл мэндийн байгууллагын 1863 ажилтан бүртгэл үүсгэн эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн 403 тохиолдол, 160 эрсдэлийн тохиолдлыг бүртгээд байна. | 100 |
| 144. | Үйлчлүүлэгчийг танин тодруулах, аюулгүй тээвэрлэх, хүлээлцэх заавар боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна. | Зааврын хэрэгжилтийн хувь | - | Зааврыг батлуулж, эрүүл мэндийн байгууллагад хэрэгжүүлсэн байна. | II-III улирал | ЭТҮГ-ЭТЧАБХ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/352 тушаалаар “Үйлчлүүлэгчийг танин тодруулах журам-”ыг баталсан. Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх, хүлээлцэх зааврын төслийг боловсруулан ЭМЯ-ны цахим хуудсанд байршуулж санал авсан. Мөн ЭМБ-аас ирсэн саналыг зааврын төсөлд тусган газрын дарга нарт танилцуулж байна. | 90 (85) |
| 145. | Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин бодолтын загвар боловсруулж батлуулна. | Батлагдсан тушаал | - | Эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин бодолтын загвар батлагдаж, байгууллагууд | I-IV улирал | СЭЗГ-СДХ | ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн ажилтнуудын ажлын чанар, үр дүн, бүтээмжид тулгуурлан цалин | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мөрдөж эхэлсэн байна. | | | хөлс, урамшууллыг олгох зорилгоор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох тодруулгыг авч Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд нийцүүлэн төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга нарт 2022 оны 4 дүгээр сард 1а/1670 дугаартай албан тоотоор чиглэл хүргүүлсэн.<br>Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс цалингийн гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн гаргаж Эрүүл мэндийн сайд, харьяа лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, МЭМАҮЭХ болон бусад эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулсан. Мэргэжлийн төрлөөр их эмчийн дундаж цалин 1.48-2.34 сая төгрөг, сувилагч, тусгай мэргэжилтний дундаж цалин 1.31-1.60 сая төгрөг, үйлчилгээний ажилчид 0.92-1.16 сая төгрөг байгаа боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чанар, тоо хэмжээний | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэлээс хамаарч цалин хөлс харилцан адилгүй олгогдож байна. Байгууллагын гүйцэтгэлийн санхүүжилтийг цалин, урамшууллын тогтолцоотой уялдуулах зорилтын хүрээнд ГССҮТ, ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ, АӨСҮТ, ХСҮТ, СЭМҮТ, зарим аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд байгууллагын үнэ, цэнэ бүтээмжийн урамшууллын журмыг байгууллагын даргын тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Цаашид эдгээр журмуудыг нэгтгэж Эрүүл мэндийн салбарын жишиг журмыг батлуулахаар ажиллаж байна. | |
| 146. | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, санал боловсруулж хүргүүлнэ. | Хүргүүлсэн албан тоот, тооцоолол | ЗГ-ын2019 оны 472 дугаар тогтоол хэрэгжиж байна. | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэх тооцооллыг ХНХЯ, СЯ-нд хүргүүлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, санал боловсруулан СЯ, ХНХЯ-тай хамтран ЗГ-ын газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг батлуулсан. Тогтоолын дагуу ажилласан жилээс хамаарч дунджаар үндсэн цалингийн хэмжээг 8 | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | орчим хувиар нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын дундаж цалин хөлс 2022 оны 9 дүгээр сарын /үр дүнгийн урамшуулал олгоогүй үеийн цалингийн олголтыг тооцон үзэхэд/ 1.49 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 203.0 мянган төгрөг (15.8 хувь)-өөр, 2020 оны мөн үетэй харьцуулахад 364.8 мянган төгрөг (32.5 хувь)-өөр тус тус нэмэгдсэн байна. | |
| 147. | Төрийн сангийн үйл ажиллагаанд Эрхийн бүртгэлийн сан систем нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Цахимаар хийгдсэн гүйлгээний эзлэх хувь | - | Цалингийн гүйлгээнээс эхлээд үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | СЯ болон Санхүүгийн тогтвортой хөгжлийг дэмжих төслөөс нэвтрүүлж буй төсвийн байгууллагуудын цахим бүртгэлийн систем Эрхийн бүртгэлийн сан болох finance.gov.mn-д ЭМЯ болон харьяа нийт байгууллагыг бүртгэн, үндсэн болон нэмэлт санхүүжилтын дансуудыг бүрэн холбосон. Мөн тухайн байгууллагын 1, 2 дугаар гарын үсэг зурдаг, цалингийн нягтлан бодогч нарыг эрх бүхий албан тушаалтны цахим мэдэгдэл, бусад холбогдох баримт бичгүүдийг тухайн дансанд холбон байршуулсан.<br>Систем нэвтэрсэнтэй | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдуулан СЯ-ны төрийн сангаас зохион байгуулсан төрийн сангийн мэргэжилтнүүдэд зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.<br>Эрхийн бүртгэлийн сангийн системээр дамжуулан цалингийн гүйлгээ, ХАОАТ, НДШ-ийн зарлагын гүйлгээнүүд, хөрөнгө оруулалтын гүйлгээнүүд цахимаар хийгддэг болсон. | |
| 148. | Эрүүл мэндийн сайдын багцын байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулна. | Зөрчилгүй санал дүгнэлтийн тоо | - | Аудитын дүгнэлт гарсан байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэн, дүгнэлт гаргуулсан. Зөрчилгүй санал дүгнэлт авсан 88 байгууллага, түүвэрт хамрагдан 9, хязгаарлалттай 17, сөрөг 6 байгууллага байна.<br>Аудит хийсэн санхүүгийн тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 4 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлж Засгийн газрын нэгтгэл тайланд тогтоосон хугацаанд оруулсан. 2021 оны Эрүүл мэндийн сайдын багцын | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгдсэн тайланд Үндэсний аудитын газраас 3 зөвлөмж, 5 албан шаардлага өгсөн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийн хувь 82,3 байна. | |
| 149. | Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангийн программыг бүрэн нэвтрүүлнэ. | Цалингийн нэгдсэн санг ашиглаж байгаа эрүүл мэндийн байгууллагын тоо | Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангийн программ нэвтэрч эхэлсэн. | Эрүүл мэндийн ажилтнуудад хуулийн дагуу олгох мөнгөн тэтгэмжийн төлөвлөлт, зохицуулалт, олголтод программыг ашигладаг болсон байна. | I-IV улирал | СЭЗГ-СДХ | Эрүүл мэндийн яамны харьяа нийт эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин хөлс, урамшууллыг “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-ээр дамжуулан шууд олгож байна. Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн дагуу эрүүл мэндийн ажилтнуудад олгох мөнгөн тэтгэмжийн төлөвлөлт, зохицуулалт, олголтыг системд хөгжүүлэлт хийж байгаа гэсэн тайлбарыг Сангийн яамнаас ирүүлсэн тул хугацаа хойшилсон. | 90 |
| 150. | ЗГҮАХ 2.1.13.3 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно. | ТББ-аас Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийсэн тоо | - | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагаар үнэлгээ хийгдсэн байна. | II-III улирал | ЭТҮГ-АЛШТХ | АХБ-ны төслөөр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил”-ийн зөвлөх багаас Монгол улсын ЭМАШТҮ-ний өнөөгийн байдлыг үнэлж, дүгнэн, тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, үр ашиг, чанар, хүртээмжийг сайжруулах тогтолцооны шинэчлэлийн чиг хандлагыг тодорхойлох зорилго бүхий “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлын түргэвчилсэн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээ 2022 оны 6 сард хийгдсэн байна. | |
| 151. | ЗГҮАХ 2.1.14.2 Сумдын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. | Батлагдсан ажлын даалгавар, зураг төсөл | - | Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна. | I-IV улирал | СЭЗГ-ХОХ | 330 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн судалгааг бүрэн гаргаж дууссан. Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн зураг төслийн даалгаврыг боловсруулан, нэг маягийн зураг төсөл хийгдэж 100 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажих шатандаа байна. | 100 |
| 152. | ЗГҮАХ 2.1.14.1 МУХТЖҮЧ-2.2 МУХТ 2.1.29 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно. | Шинээр орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болсон сумын ЭМТ-ийн тоо | Ариун цэврийн төвлөрсөн болон хэсэгчилсэн системд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо-98. | 3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна. | II, IV улирал | НЭМГ-УСХЗХ | ЭМЯ, НЭМҮТ, МХЕГ хамтран “Ус, ариун цэврийн байгууламжийн түргэвчилсэн үнэлгээ хийх” судалгааны асуумжийг боловсруулж, 21 аймгийн ЭМГ-ын орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт асуумж авах аргачлалын талаар цахим сургалт зохион байгуулсан. Нийт 21 аймгийн 358 сумын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах систем, ус хангамж, гарын эрүүл ахуй, ЭМБХХМ-ийн нөхцөл байдлын талаар нэгдсэн судалгааг гаргасан. | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төв аймгийн 5 сум, Завхан аймгийн 5 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох ажлын хүрээнд Тендерийн үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулж, 2022 оны Төсвийн тухай хуулийн тодотголоор 360 сая төгрөг батлагдсан бөгөөд тендер шалгаруулалт, худалдан авах үйл ажиллагаа хийгдэж байна. | |
| 153. | МУХТЖҮЧ 2.2.7; Уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэлийн эрхзүйн орчинг шинэчилнэ. | Шинэчлэгдэн батлагдсан уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэл | - | Уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэлийг шинэчлэн батлуулсан байна. | III улирал | ЭТҮГ-УАУХ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/208 дугаар тушаалаар уламжлалт эмийн чанар аюулгүй байдлын асуудлаар ажлын хэсгийг байгуулсан. уламжлалт эмийн бүртгэлийн үйл ажиллагааны нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, улсын бүртгэлд бүртгүүлэх журмын төсөлд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг гарган ЭЭХХЗГ-тай уулзалт зохион байгуулсан.<br>“Уламжлалт анагаах ухааны салбарын өнөөгийн нөхцөл, хэтийн төлөв: Асуудал, шийдэл” сэдэвт үндэсний зөвлөгөөнөөр “Уламжлалт эмийн чанар аюулгүй байдал” салбар хуралдааныг зохион байгуулж | 30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцэн цаашид анхаарах асуудлын талаарх зөвлөмжийг гарган ЭЭХХЗГ-т 2022 оны 1а/5057 албан тоотоор зөвлөмж хүргүүлсэн<br>ЭЭХХЗГ чиг үүргийн дагуу эмийн бүртгэлийн журмыг боловсруулах, санал авах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд эмийн бүртгэлийн журмын төсөлд албан бичгээр санал хүргүүлсэн. | |
| 2.3. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | | |
| 154. | ЗГҮАХ 2.3.1.1<br>Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэхэд БШУЯ-тай хамтран ажиллана. | Хүргүүлсэн санал, батлагдсан шийдвэр | - | Холбогдох чиглэлээр гарсан эрх зүйн баримт бичгүүдэд санал хүргүүлсэн байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | “Яслийн үйлчилгээг зохион байгуулах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/4 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Яслийн үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх журмын төслийг эцэслэн боловсруулахад ЭМЯ-наас 1а/2470 тоот албан бичгээр санал хүргүүлж хамтран ажилласан. Төсөл эцэслэн бэлэн болсон боловч Боловсролын багц хуулийн өөрчлөлтийн зарчмын хүрээнд Олон улсын байгууллагуудын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвлөмжийн дагуу 0-2 насны хүүхдийг эхтэйгээ цуг гэртээ байх зөвлөмжийг үндэслэн тус ажлыг хэсэг ЗГҮАХ 2.3.1.1-ийн хэрэгжилтийг эргэн харах шаардлагатай гэж шийдвэрлэсэн. Иймд, 0-2 насны хүүхдийн асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/326 дугаар тушаалаар "Бага насны хүүхдийн цогц хөгжил" арга хэмжээнд нэгтгэн тусгахаар шийдвэрлэсэн, тодруулбал 0-3 хүртэл насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг олон хувилбартай болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэж байгаа болно. ЭМЯ-ны зүгээс ажлын хэсэгт ажиллаж, 4 удаагийн хуралд оролцож, төсөлд 2022 оны 3/4723, 1а/5066 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн байна. | |
| 155. | ЗГҮАХ 2.3.2.6<br>Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | Хамтран хэрэгжүүлэх ээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтий н хувь | - | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд дангаар болон хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогын төсөлд 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр цахимаар санал хүргүүлсэн. “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих” баримт бичгийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/326 дугаар тушаалаар шинэчлэн | 70 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баталсан ба тус ажлын хэсгийн 4 удаагийн хуралд оролцож төсөл дээр хамтран ажилласан. БШУЯ-нд 2022 оны 3/4723 дугаар албан бичгээр төсөлд санал хүргүүлсэн. 2022 оны 1а/5066 дугаар албан бичгээр “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлсэн. БШУЯ тогтоолын төслийг 12 дугаар сарын 14-ны Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. | |
| 156. | ЗГҮАХ 2.3.4.6<br>МУХТ 2.3.7<br>Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгоно. | Хүргүүлсэн санал | Ялгаатай хэрэгцээ-тэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах журам батлагдсан. | Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд холбогдох чиг үүргийн дагуу оролцсон байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/110 дугаар тушаалаар Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролыг дэмжих төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний 6 дахь заалт “Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд монгол хэлний хичээлийг хос хэлний арга зүйгээр заах арга зүйн зөвлөмж боловсруулах /23,616,000 төг/, 11 дэх заалт МУБИС-ийн “Тусгай хэрэгцээт боловсролын багш” бакалаврын сургалтын хөтөлбөрт монгол дохионы хэлний анхан, ахисан шатны хөтөлбөр боловсруулах /117,000,000 төг/ ажлын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санхүүжилтийг шийдэж ажлын хэсгүүд ажилласан.<br>Эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад тогтмол хамрагдах боломжгүй хүүхдэд ганцаарчилсан сургалтаар хичээллэхэд дэмжлэг үзүүлэх “Жишиг сургалтын хөтөлбөр” боловсруулах ажлыг мөн эхлүүлээд байна. | |
| 157. | ЗГҮАХ 2.3.8.5 Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлнэ. | Сургагдсан багшийн тоо | - | Сургалтын хөтөлбөрийг сайжруулахад оролцож хамтран ажилласан байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй ажиллах сонирхолтой аргууд, хөгжлийн бэрхшээл, жендэр болон соёлын мэдрэмжтэй олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг төслийн зорилтот аймгуудад нийт 73 оролцогчийг (эмэгтэй 78.1%) хамруулан зохион байгуулсан. Сургалтад эцэг эхийн төлөөлөл 8, нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн салбар, Төрийн бус байгууллагын төлөөлөл 6, төслийн зорилтот биш сургуулийн төлөөлөл 3 оролцогч хамрагдсан. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах төслийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, Өмнөговь аймгийн БШУГ-ын тэгш хамруулах боловсролын 45 | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэргэжилтний сургалтыг 2022 оны 3, 4 дүгээр сард Боловсрол шинжлэх ухааны яамтай хамтран зохион байгуулсан. | |
| 158. | ЗГҮАХ 2.3.10.1 МУХТЖҮЧ 2.1.9 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлнэ. | Стандартын шаардлагад нийцсэн хоолны газартай ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны эзлэх хувь | - | Ерөнхий боловсролын сургуулийн хоолны газрын 30 хувийг стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | I-IV улирал | НЭМГ-УСХЗХ | Сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Боловсрол шинжлэх ухааны сайдын сайдын 2021 оны А/75 дугаар тушаалаар баталсан. 2022 оны 04 дүгээр сарын 13-нд тус стандартын төслийн эхний хэлэлцүүлэгт оролцон ажиллаж, 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр төсөлд холбогдох саналыг цахимаар хүргүүлсэн. 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр БШУЯ-аас ЭМЯ, СХЗГ, ШУТИС, холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, стандартын төслийг дахин санал солилцож хэлэлцэн сайжруулав. Тус стандартын төсөлд ЭМЯ-наас 2022 оны 2/4458 дугаар албан бичгээр БШУЯ-нд санал хүргүүлсэн. БШУЯ тус төсөлд санал авахаар 15 байгууллагад хүргүүлж саналыг нэгтгэж | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эцэслэн хэрэгжилтийн гарааны нөхцөлийн үнэлгээ хийж, СХЗГ-т батлуулахаар хүргүүлсэн байна. | |
| ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | | |
| 4.2. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | | | |
| 159. | ЗГҮАХ 4.2.5.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | Зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо | Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байгаа. | Сургалт сурталчилгаа явуулж, үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайлыг хангаснаар ёс зүйн зөрчил буурсан байна. | I-IV улирал | ТЗУГ | Яамны нийт албан хаагчдаас сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгааг хагас, бүтэн жилд 2 удаа асуумжаар авч, судалгаанд үндэслэн 2022-2023 оны сургалтын төлөвлөгөөг ТНБД-ын 2022 оны А/79 дүгээр тушаалаар батлуулсан. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэв: Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежерийн сургалтад (магистрийн түвшин) 2 албан хаагч суралцаж байна. Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу тэргүүн түшмэлийн сургалтад-1, эрхэлсэн түшмэлийн сургалтад-11 (улсын зардлаар-9, хувийн зардлаар-2), ахлах түшмэлийн-3, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-4, мэргэшүүлэх давтан сургалтад-2, нийт 21 албан хаагчийг тус тус хамруулсан.<br>Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглүүлэх богино хугацааны болон төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны, мэргэшүүлэх багц цагийн сургалтад нийт 11 албан хаагчийг хамруулсан.<br>Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Үүнд:<br>Яамны албан хаагч нарт Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт зохион байгуулж, 58 албан хаагч,<br>Алсын хараа- 2050 Монгол улсын урт, хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үе шат “шинэ сэргэлтийн бодлого”-ын 2 өдрийн сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж, ЭМЯ, харьяа байгууллагын нийт 98 удирдах албан тушаалтан,<br>Байгууллагын удирдлагын манлайлал, санхүүгийн менежмент, удирдах аижлтны ёс зүйн манлайлал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр 2 өдрийн сургалт зохион байгуулж, ЭМЯ, яамны харьяа 20 байгууллага, 21 аймгийн НЭ-н удирдлагууд нийт 70 албан тушаалтан тус тус хамрагдсан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| 160. | ЭМЯ-ны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулна. | ТАЗ-өөр хянагдаж, баталгаажсан АБТ-ын тоо | ЭМЯ-ны бүтэц шинэчлэгдэн батлагдсан. | ЭМЯ-ны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан байна. | I-IIулирал | ТЗУГ | ТНБД-ын 2021 оны А/130 дугаар тушаалаар батлагдсан “ЭМЯ-ны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны стратеги, ажлын байрны чиг үүрэг”-ийн дагуу яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ТНБД-ын А/176 дугаар тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн 3 удаагийн хурлыг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу АТТ-ыг боловсруулж ТАЗ-н холбогдох албан тушаалтнаар хянуулж, зөвлөлийн хуралд танилцуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 80, 86, 94, 95 дугаар тогтоолоор удирдах албан тушаалын 18, гүйцэтгэх албан тушаалын 73 АТТ-ыг батлуулсан. Батлагдсан АТТ-ыг албан хаагчдад хувийг хүргүүлж танилцуулав. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 161. | Яамны дэргэдэх ТАЗСЗ-ийн үйл ажиллагааг хариуцан ажиллана. | ТАЗСЗ-ийн тайлан | ТАЗСЗ-ийн үйл ажиллагаа тогтмолжсон. | ТАЗСЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг ТАЗ-д хүргүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ | Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан 9 чиглэлийн үйл ажиллагааны тайланг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ТНБД-ын 2022 оны 2/89 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2022 онд нийт 8 удаагийн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулсан.<br>Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс дараах ажлуудыг гүйцэтгэсэн.Үүнд.<br>ЭМЯ, ЭМДЕГ, ЭЭХХЗГ-ын төрийн албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын нийт 101 ажлын байрны тусгай шалгалтыг зохион байгуулсан (ЭМЯ-удирдах-6, гүйцэтгэх-28, ЭЭХХЗГ-ын гүйцэтгэх-20, удирдах-4, ЭМДЕГ-ын гүйцэтгэх-34, удирдах-9).<br>ЭМЯ, ЭМДЕГ, ЭМДҮЗ-ийн ажлын албаны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох, ахиулан олгох асуудлыг хэлэлцэж журмын дагуу шийдвэрлэн Салбар зөвлөлийн тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулав.<br>Ерөнхий сайдын захирамжаар яамны эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ахиулах-2, эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгох-1 асуудлыг ТАЗ-д уламжилж, шийдвэрлүүлэв.<br>Төрийн захиргааны 68 албан хаагчийн төрийн захиргааны тангараг өргөх ёслолын бэлтгэл ажлыг хангаж, ёслолын арга хэмжээг 7, 11 дүгээр сараудад зохион байгуулсан.<br>Төрийн албаны Тэргүүний ажилтнаар 2 албан хаагчийг нэр дэвшүүлж, холбогдох материалыг хүргүүлэв.<br>Тусгай шалгалтын 7 удаагийн комиссын хуралдаан зохион байгуулагдсан.<br>Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, төрийн албаны тусгай шалгалт, шатлан дэвших журам, төрийн албан хаагчийн хувийн хэргийн шинэчлэн мөрдөх журам, төрийн үйлчилгээний удирдах болон тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын холбогдох ангилалд дүйцүүлэх жагсаалтын боловсруулахад салбар зөвлөлийн гишүүд оролцож, Засгийн газрын тогтоолын төсөлд санал хүргүүлсэн.<br>Нийт 8 удаагийн хурлаар 19 тогтоолын шийдвэр гаргав. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | |
| 5. Сайд, дэд сайд, удирдлага болон яамны аппаратын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх | | | | | | | | |
| 162. | Эрүүл мэндийн сайдтай Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулна. | Гарын үсэг зурж, баталгаажсан гэрээ | Гэрээг жил бүр байгуулдаг. | Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулж, батлуулсан байна | I улирал | БТГ-СУХ | 2022 онд Аймаг нийслэлийн Засаг дарга нартай Эрүүл эндийн сайдын хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ-аас санал авч тусган боловсруулсан. Гэрээг 2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Засаг дарга нартай байгуулсан. | 100 |
| 163. | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг Засгийн газарт хүргүүлнэ. | Засгийн газарт хүргүүлсэн тайлан | Тайланг улирал тутам хүргүүлдэг. | Засгийн газарт тайланг улирал тутам хүргүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ХХ | ЗГ-ын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 6 эрүүл мэндийн байгууллага (УХТЭ, СЭМҮТ, ХСҮТ, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг)-ыг холбох тухай хүсэлтийг 2022.02.21-ний өдрийн 2/758 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, шийдвэрлүүлсэн. Уг ажлын хүрээнд дээрх 6 байгууллагад 11-11 төвийг хариуцах албан хаагчийг томилж, программыг эмнэлэг тус бүрээр суулган, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 2022 оны эхний 11 сарын байдлаар ЭМЯ хариуцан шийдвэрлэх 2222 | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өргөдөл, гомдол, талархал ирүүлсэн байна. Өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлсэн иргэдтэй утсаар холбогдож, яамны газар, хэлтсүүдтэй хамтран гомдлыг шийдвэрлэж, санал хүсэлтийг холбогдох албан тушаалтанд уламжилж ажилласан. Гомдлын 45% нь коронавируст халдвартай холбоотой, 17% нь эмч ажилчдын харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой, 12% нь эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой, 11% нь талархал, 6% нь эмнэлгийн ажилчдын цалин урамшуулалтай холбоотой, 9% нь бусад байна. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй. Шийдвэрлэлт: 95.4%<br>11-11 төвд ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг 2022 оны 04 дүгээр сараас эхлэн сар бүр хэвлэлийн хурлаар олон нийтэд мэдээлж хэвшсэн. Нийт 7 удаа хэвлэлийн хурал хийсэн.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/50 дугаар тушаалаар “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журмыг батлуулан, харьяа эрүүл мэндийн байгууллагуудад | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлж, эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулсан. 2022 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын тайланг 1а/1511 тоот албан бичгээр, 2022 оны эхний хагас жилийн тайланг 1а/3216 тоот албан бичгээр, 3 дугаар улирлын тайланг 2/4448 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Жилийн эцсийн өргөдөл гомдлын тайланг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны дотор ЗГХЭГ-т хүргүүлнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 214 дүгээр захирамжаар иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх шуурхай штаб байгуулахыг даалгасан. Тус захирамжийн дагуу ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах тухай" А/144 дүгээр тушаалыг батлуулж 2022 оны 12 дугаар сарын 09-өөс 12-ны өдрүүдэд 3 хоногийн хугацаанд Шуурхай штаб ажиллаж ЭМЯ болон харьяа 24 байгууллагын хэмжээнд нийт 68 өргөдөл, | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гомдол хүлээн авснаас 37 өргөдлийг тухайн өдөртөө шийдвэрлэж ажилласан байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт-54.4% байна. | |
| 164. | Салбарын хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргана. | ХШҮДАГ-т хүлээлгэн өгсөн тайлан | Тайланг улирал тутам гаргадаг | ХШҮДАГ-т тайланг улирал тутам хүргүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ-ХХ | Хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, ҮАБЗ-ийн зөвлөмж, ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, ЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн тайланг ХШҮДАГ-т 2022.02.10-ний өдөр, 2022 оны эхний хагас жилийн тайланг ХШҮДАГ-т 2022.07.05-ны өдөр хүргүүлсэн.<br>Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг сар тутамд нэгтгэн, ЗГХЭГ-ын харьяа www.unelgee.gov.mn цахим хуудаст байршуулж байна.<br>2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 2023.02.15-ны дотор нэгтгэн гаргаж ХШҮДАГ-т хүргүүлнэ. | 100 |
| 165. | Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг | Батлагдсан төлөвлөгөө, хагас бүтэн | Журмын дагуу боловсруу | Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан | I, II, IV улирал | ТЗУГ | Яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлгөөний эхний хагас жилийн тайланг 06 дугаар | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, батлуулан, хагас бүтэн жилээр биелэлтийг гаргана. | жилээр гаргасан биелэлтийн тайлан | лж батлуулдаг. | байна. | | | сарын 20-ны өдөр ХШҮДАГ-т хүлээлгэн өгсөн. Яамны 2022 оны жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 16-ны дотор багтаан ХШҮДАГ-т хүлээлгэн өгөхөөр нэгтгэж байна. | 100 |
| 166. | ЭМЯ-ны харьяа байгууллагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж баталгаажуулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангана. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг батал-гаажуулсан ЭМЯ-ны харьяа байгууллагын тоо | ЭМЯ-ны харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж Эрүүл мэндийн сайдаар батлуулдаг. | ЭМЯ-ны харьяа байгууллагуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж Эрүүл мэндийн сайдаар баталгаажуулсан байна. | I улирал | ТЗУГ | ЭМЯ-ны харьяа 27 байгууллагын холбогдох мэргэжилтнүүдтэй тус бүр 3-5 удаа уулзаж арга зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай засварыг хийж, бүх байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг I улиралд багтаан Эрүүл мэндийн сайдаар баталгаажуулсан. | 100 |
| 167. | ЭМЯ-ны харьяа байгууллагын дарга нарын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулна. | Шинэчлэгдсэн хөдөлмөрийн гэрээ | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж 2022 оноос хэрэгжиж эхэлсэн. | Шаардлагатай хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж баталгаажуул-сан байна. | I –IV улирал | ТЗУГ | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй уялдуулан Хөдөлмөрийн гэрээг шинээр боловсруулсан. 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр Эрүүл мэндийн сайд харьяа байгууллагын дарга нартай хөдөлмөрийн гэрээг | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан. | |
| 168. | Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн асуудлаар төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Тусдаа төлөвлөгөө байдаггүй. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | I –IV улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийг хамгаалах ажлын 2022 оны төлөвлөгөө"-г ЭМЯ-ны ТНБД-аар 2022.04.27-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ХЭҮК-той хамтран "Хүний эрхийн мэдрэмж, ажлын байрны дарамт" сэдэвт сургалтыг 2022.10.28-ны өдөр эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтан болон хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан нарт, 2022.11.29-ний өдөр ЭМЯ-ны албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Сургалтад нийт 130 албан тушаалтан оролцсон. ЭМЯ-ны шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөрийн суурь зарчим ба хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын талаар шинээр 7 заалт тусгасан. | 100 |
| 169. | ЭМЯ, түүний харьяа байгууллагын Авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх ажлын 2022 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэхэд чиглэл | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг. | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | I –IV улирал | ТЗУГ | Авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэх зорилгоор ЭМЯ-ны "Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө"-г ТНБД-аар 2022.02.23-ны өдөр батлуулсан. "Авлига ашиг сонирхлын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өгч ажиллана. | | | | | | чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 2022 оны эхний хагас жилийн тайланг АТГ-ын khutulbur.iaac.mn цахим хуудсанд 2022.06.15-ны өдөрт багтаан байршуулсан. 2022.08.30-ны өдөр АТГ-тай хамтран салбарын ЭБАТ-д авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан гаргах талаар сургалт зохион байгуулсан. 2022.08.30-ны өдөр ЭМЯ-ны 72 албан хаагч болон ЭБАТ-уудад авлигын эсрэг сургалтыг танхимаар зохион байгуулсан. АТГ-аас 2022 оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан төрийн албанд шинээр томилогдсон албан тушаалтны сургалтад яамны шинээр томилогдсон 16 албан хаагч бүрэн хамрагдсан.<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийн давтан сургалтад яамны нийт 42 албан хаагч хамрагдсан. ЭМЯ, хуулийн этгээд хооронд байгуулах бүх гэрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх тухай” заалт оруулсан.<br>АТГ-ын пэйж хуудсыг идэвхтэй дагах тухай дотоод меморандумыг газар, хэлтэст хүргүүлж, яамны дотоод | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сүлжээнд байршуулсан.<br>Харьяа агентлаг, эрүүл мэндийн байгууллагад тус хуудсуудыг дагаж, хамтран ажиллах тухай 2/1356 тоот албан бичгийг 2022.03.28-ны өдөр хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу эрүүл мэндийн яамны харьяа 24 байгууллагууд байгууллагын цахим хуудсандаа Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гэсэн цэсийг нэмж, мэдээллээр баяжуулан ажиллаж байна.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль энэ оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ТНБД-ын "Журам шинэчлэн батлах тухай" А/63 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Цахим хуудас ажиллуулах, мэдээллийг цахим хуудсанд байрлуулж, түгээх, ашиглах журам, тушаалын 2 дугаар хавсралтаар Цахим хуудасны цэсэнд байрлах мэдээ, мэдээллийг бэлтгэн өгөх ажилтны ажил үүргийн хуваарийг тус тус баталсан.<br>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 1 зөвлөмж, 2 мөрдөгчийн мэдэгдэл, 1 зөрчил арилгуулах бичигт хуулийн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хугацаанд хэрэгжилтийг хангаж хариу хүргүүлсэн байна. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх ажлын 2022 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэхэд чиглэл өгч, тайланг Авлигатай тэмцэх газрын hutulbur.iaac.mn цахим хуудсанд тайлант хугацаанд байршуулсан. АТГ-аас УНТЭ-т хийсэн хяналт шалгалтын дагуу илэрсэн зөрчлийг бусад байгуулагад гарахаас сэргийлж нийт харьяа байгууллагуудын хэмжээнд хэрэгжүүлэх "Авлига ашиг сонирхлын чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г батлуулан 2022 оны 07 дугаар сард хүргүүлсэн бөгөөд тайланг 2022.12.15-ны өдөр хүлээн авна. | |
| 170. | Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл болон тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төлбөрийн жишиг | Батлагдсан журам | - | Журмыг шинэчлэн батлуулж, мөрдсөн байна. | I-II улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/143 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл болон тусгай зөвшөөрлийн үйл | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоосон журмыг батлуулна. | | | | | | ажиллагааны төлбөрийн жишиг тогтоох ажлын хэсэг байгуулсан. Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭЭХХЗГ, ЭМХТ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоодод төлбөрийн жишгийн төсөлд санал ирүүлэх тухай 2022 оны 2/1871 албан тоот хүргүүлж 11 байгууллагаас ирсэн саналыг журмын төсөлд тусган, яамны цахим хуудсанд олон нийтээс санал авахаар байршуулсан. | 50 |
| 171. | Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна. | Батлагдсан тэргүүлэх чиглэл | - | Тэргүүлэх чиглэл шинэчлэгдэн батлагдаж, мөрдсөн байна. | I-II улирал | ТЗУГ | Аймаг, нийслэлийн ЭМГ, ЭЭХХЗГ, ЭМХТ, мэргэжлийн нийгэмлэг, холбоодод санал авахаар 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 2/1846 тоот албан бичиг хүргүүлсэн. Санал ирүүлсэн 11 байгууллагуудын саналыг тэргүүлэх чиглэлийн төсөлд тусгасан. Зөвшөөрлийн тухай хууль шинээр батлагдаж 2023 оны 1 сараас мөрдөгдөж эхлэхтэй холбоотой Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тул хүлээгдэж байна. | 50 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 172. | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох цахим системийг бүрэн нэвтрүүлэх, Магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын мэдээний санг цахимжуулна. | Ашиглахад бэлэн болсон тусгай зөвшөөрлийн програм хангамж Цахим мэдээний санд бүртгэгдсэн магадлан итгэмжлэгдсэн байгууллагын хувь | - | Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох цахим систем нэвтрүүлэх бэлтгэл ажил хангагдсан байна. Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын мэдээний сан бүрдсэн байна. | I-IV улирал | ТЗУГ | ЗГ-ын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэр өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг 2022 оны 4 дүгээр сараас цахимаар хүлээн шийдвэрлэж байна.<br>Тус програмыг 2022 оны 3 дугаар сард Эрүүл мэндийн мэдээллийн технологийн хорооны хурлаар, 2022 оны 4 сард Эрүүл мэндийн мэдээлэл, технологийн зөвлөлийн нэгдүгээр хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.<br>Програм хангамжийн ажлын даалгаврын дагуу АКСИС СИСТЕМС” ХХК-аас хүлээн авч тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 6013 байгууллагуудын мэдээллийн санг тус программ хангамжид шилжүүлэн мэдээллийн сангийн ашиглалтыг хангасан.<br>Тусгай зөвшөөрлийн шинжээч нар цахимаар дүгнэлт ирүүлэх, Тусгай зөвшөөрөл олгох зөвлөлийн гишүүд хурлаар | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцэх баримт бичгүүдтэй танилцах боломжтой болсон. Тусгай зөвшөөрлийн хэрэгцээний үнэлгээ олгох шийдвэр 90-120 хоногт гарч байсныг 45-60 хоног хүртэл болж богиноссон. https://tzmoh.gov.mn/ цахим хуудсаар 2022 оны 12 сарын 09-ний өдрийн байдлаар Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон хугацаа сунгах, хаяг, нэрийн өөрчлөлт хүссэн 134 хүсэлт ирүүлснээс 97 аж ахуйн нэгж, эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийг шийдвэрлэсэн ба бусад хүсэлтийн дагуу шинжээчийн дүгнэлт гарч, 12 дугаар сарын хурлаар хэлэлцүүлнэ. | |
| 173. | Дэлхийн эрүүл мэндийн 75 дугаар чуулганд оролцоно. | Чуулганд оролцсон тайлан, мэдээлэл | Жил бүрийн чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар МУ-ынЗГ-ынбайр суурийг илэрхийлдэг. | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар МУ-ынЗГ-ынбайр суурийг илэрхийлсэн байна. | II улирал | ТЗУГ-ГХХ | ДЭМБ-ын ассабмлейн 75 дугаар чуулганд оролцохтой холбоотойгоор төлөөлөгчдийн Ажлын удирдамж, танилцуулга, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл болон Эрхийн үнэмлэхний төсөлд ГХЯ-ны саналыг авч, 2022 оны 1а/2169 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГ-ын 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, удирдамжийг Ерөнхий Сайдаар батлуулсан. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Чуулганд оролцох төлөөлөгчдөд ГХ-ны Сайдын гарын үсэг бүхий Эрхийн үнэмлэхийг гаргуулж, цахим бүртгэлийг Женев дэх Байнгын төлөөлөгчийн газраар гүйцэтгүүлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанд Сайдын хэлэх үгийг англи хэлээр боловсруулж ДЭМБ-д хүргүүлсэн. Сайд ДЭМБ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд МУ-ын ЗГ-ын байр суурийг илэрхийлсэн. Ажлын удирдамжид заасны дагуу Чуулганы А хорооны хуралдаанаар авч хэлэлцсэн асуудлуудаас 7 асуудлаар МУ-ын ЗГ-ын байр суурийг илэрхийлсэн.<br>Чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудсыг ГХЯ, ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанд танилцуулав. | |
| 174. | Ази, Номхон далайн бүсийн Парламентчдын Дэлхийн эрүүл мэндийн VI форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулна. | Форум зохион байгуулсан тайлан, мэдээлэл | Монголд анх удаа зохион байгуулагдана. | Хурал зохион байгуулагдсан байна. | IV улирал | ТЗУГ-ГХХ | Ази, Номхон далайн бүсийн Парламентчдын Дэлхийн эрүүл мэндийн VI форумыг КОВИД-19 цар тахлын улмаас зохион байгуулалгүй 2 жил хойшлуулсны эцэст Форумыг санаачлагч БНСУ-ын Үндэсний | 90 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Парламентын зүгээс 2022 оны хоёрдугаар хагаст өөрийн улсад форумыг зохион байгуулахаар ДЭМБ-тай тохиролцсон талаар ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн захирал Др. Такеши Касай 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн WP/2022/Meeting/17/2022 албан бичгээр Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт мэдэгдсэн болно. Уг албан бичигт 2023 онд дээрх Форумын VII хуралдааныг Монгол Улсын Их Хуралтай хамтран Улаанбаатар хотод зохион байгуулах санал тавьсан ба УИХ-ын даргаас зөвшөөрсөн хариуг 2022 оны 4 дүгээр сард ДЭМБ-д хүргүүлсэн.<br>Манай улсад VI форумыг зохион байгуулаагүй ч гэсэн УИХ-ын дарга Г.Занданшатар, УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн нар дээрх форумд 2022 оны 8 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд оролцохтой холбоотой бүх бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Үүнд: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн панелистээр оролцох 2 сэдэвчилсэн хэлэлцүүлэгийн 2 презентаци, УИХ-ын дарга Г.Занданшатарын форумын хаалт дээрх хэлэх үгийг тус тус | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | англи хэлээр боловсруулж бэлтгэн УИХ-ын Тамгын газарт, УИХ-ын гишүүний Ажлын албанд тус тус хүргүүлсэн болно. | |
| 175. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны 73 дугаар чуулганд оролцоно. | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар МУ-ынЗГ-ынбайр суурийг илэрхийлсэн байна. | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар МУ-ынЗГ-ынбайр суурийг илэрхийлэх | Олон талт хамтын ажиллагаа өргөжин хөгжсөн байна. | IV улирал | ТЗУГ-ГХХ | Эрүүл мэндийн сайд тэргүүтэй төлөөлөгчид 2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо хуралдсан ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн хорооны 73 дугаар чуулганд оролцсон. Чуулганд оролцохтой холбогдуулан танилцуулга, ажлын удирдамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл боловсруулж Гадаад харилцааны сайдад албан бичгээр хүргүүлэн саналыг авч тусган, эцэслэсэн. ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлж, Эрүүл мэндийн сайдын албан томилолтыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, ажлын удирдамжийг Ерөнхий сайдаар батлуулсан.<br>Чуулганаар хэлэлцэн баталсан “Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянах цогц арга хэмжээний хүрээ 2023-2030”, “Сэтгэцийн эрүүл мэндийн талаар баримтлах стратегийн баримт бичгийн | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээ 2023-2030", "Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагааны хүрээ", "Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стратегийн хүрээ", "Хүрч үйлчлэхэд хэцүү иргэн нэг бүрт хүрэх стратегийн зорилтын хүрээ 2022-2030" зэрэг чиглэлээр Номхон далайн баруун бүсийн улс орнуудад урт хугацаанд баримтлах стратегийн баримт бичгүүдийн төслүүдийн хэлэлцүүлэг тус бүрт Монгол Улс оролцож байр сууриа илэрхийлэв. Гадаад томилолтын дүнгийн талаарх илтгэх хуудас болон дүнг ажлын 3 хоногт багтааж ГХЯ-нд хүргүүлэн, улмаар Засгийн газрын хуралдаанд танилцуулж, томилолтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон холбогдох газруудад хүргүүлсэн болно. | |
| 176. | Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлнэ. | Шинээр хэрэгжүүлсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ | - | Шинээр хэрэгжүүлэх төсөл батлуулсан байна. | I-IV улирал | ТЗУГ-ГХХ | "Халдварт өвчний хяналтын тогтолцоог бэхжүүлэх" 7.5 тэрбум солонгос воны санхүүжилт бүхий төслийн саналыг ХӨСҮТ-тэй хамтран боловсруулж БНСУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг КОЙКА-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр СЯ-нд 2022 оны | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2 дугаар сарын 28-ны өдөр албан бичгээр хүргүүлэв. Төслийг саналыг санхүүжүүлэх шийдвэрийг КОЙКА-аас гаргасан. Төслийг БНСУ-ын Өвчний хяналт сэргийлэлтийн төвтэй хамтран 2023-2027 онуудад хэрэгжүүлнэ.<br>“Эхээс хүүхдэд ХДХВ, Гепатит В вирус болон Тэмбүүгийн халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх” төслийн саналыг боловсруулж БНХАУ-ын Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны тусламжийн санд СЯ-аар дамжуулан хүргүүлсэн. Төслийн санхүүжилтийн хэмжээ 740,339 ам.доллар.<br>ЭМЯ-ны харьяа ГССҮТ-ийн “Яаралтай тусламж, оношилгоо, нөхөн сэргээх тасгийг бэхжүүлэх” 7,5 сая еврогийн өртөг бүхий төслийн саналыг монгол, англи хэлээр боловсруулан, танилцуулгын хамт албан бичгээр 2022 оны 4 дүгээр сард хүргүүлсэн байна. Бельгийн Хаант Улсаас БНХАУ-ын Бээжин хотноо суугаа Элчин сайдын яамаараа дамжуулан уг төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн болохоо 2022 оны 4 дүгээр сард төлөөний ноотоор манайд мэдэгдсэн болно. Хувийг ГХЯ, СЯ хүлээн | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авсан. Нийт санхүүжилтийн хэмжээ: БНСУ-аас 19,800,000.00 төгрөгийн санхүүжилтийг техникийн хамтын ажиллагааны хэлбэрээр шийдвэрлүүлсэн.<br>Бельгийн Хаант Улсын Засгийн газраас 27,049,050 төгрөгийн хүүгүй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг батлуулсан. | |
| 177. | МУ-ын Эрүүл мэндийн яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын эрүүл мэнд, нийгмийн халамжийн яам хоорондын Зөвлөлдөх ажлын хэсгийн ээлжит хуралдааныг зохион байгуулна. | Хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний батлагдсан төлөвлөгөө | Зөвлөлдөх ажлын хэсэг жил бүр хуралддаг. | Төлөвлөгөөт арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна. | III-IV улирал | ТЗУГ-ГХХ | 2022 оны 5 дугаар сард Женев хотноо хуралдсан Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 75 дугаар чуулганы үеэр БНСУ-ын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын Ерөнхий захирал Юн Чан-сик, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга У Кёнг-ми нартай хоёр талын уулзалт зохион байгуулж, “Сөүл төсөл”-ийн хэрэгжилт болон хоёр улсын Эрүүл мэндийн яамд хоорондын Зөвлөлдөх уулзалтыг сэргээх талаар болон тус улсын Өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн үйл ажиллагааг судлах зэрэг өргөн хүрээтэй асуудлаар санал солилцож ярилцсан. Тус улсын хувьд Ерөнхийлөгчийн сонгуулийн мөрөөр шинэ Засгийн газар байгуулагдаж | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгаа ба Эрүүл мэнд, нийгмийн халамжийн сайд хараахан томилогдоогүйтэй холбоотойгоор Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах талаар тодорхой тов товлох боломжгүй байгааг мэдэгдсэн. Мөн тус улсад КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал бүрэн хяналтад ороогүй байгаа тул гадаадын эмч мэргэжилтнүүдэд зориулсан эмнэлзүйн сургалтыг биетээр зохион байгуулах шийдвэр гаргаагүй хэвээр байгааг мэдэгдсэн.<br>Улмаар Эрүүл мэнд, нийгмийн халамжийн сайд болон дэд сайд нар томилогдож, шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан үед дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл үүсэх талаар мэдээлсэн.<br>БНСУ-д суух Монгол Улсын шинэ Элчин сайд Итгэмжлэх жуух бичгээ барьсан үед зогсонги байдалд орсон дээрх асуудлуудаар тус улсын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яамны удирдлагатай уулзалт хийж, ноот бичгээр албан хүсэлтээ шуурхай хүргүүлэх талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд 2022 оны 5 дугаар | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сард Элчин сайдаар томилогдсон албаны хүмүүстэй уулзалт хийх үедээ мэдэгдэж, албан бичгийн хувийг гардуулсан болно.<br>2022 оны 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо чуулсан ДЭМБ-ын Номхон далайн баруун бүсийн 73 дугаар чуулганд оролцох үеэр БНСУ-ын Эрүүл мэнд, нийгмийн халамжийн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дэд захирал /шинээр томилогдсон хүн байсан/-тай хоёр талын уулзалт хийж, өмнө Женев хотноо ярилцсан асуудлуудаар 2023 онд ахиц гаргах талаар харилцан саналаа солилцсон. | |
| 178. | Яамны төрийн нууцтай холбоотой үйл ажиллагааг хууль журмын хүрээнд зохион байгуулна. | Нууцын үйл ажиллагаатай холбоотой зөрчил гараагүй байна. | Хууль, журмын хүрээнд нууцын үйл ажиллагааг зохион байгуулдаг | Нууцтай холбоотой үйл ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан байна. | I-IV улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн яамны 2021 онд хийсэн ажлын тайланг ТЕГ-т 2022 оны 2/008 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2011 оныг дуустал ЭМЯ-нд нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийг ил болгох ажлыг хийж ТЕГ-ын саналыг авахаар хүргүүлсэн.<br>Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэх ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>ТЕГ-ын аюулгүй байдлын шалгалтад хамрагдсан 4 албан хаагчаас нууц задруулахгүй баталгааг гаргуулж авав.<br>Эрүүл мэндийн сайдын 2021 А/155 дугаар тушаалаар батлагдсан төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий 4 албан тушаалтанг аюулгүй байдлын шалгалтад хамруулж, нууц задруулахгүй баталгааг гаргуулж, арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.<br>Онц нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөөний төслийг боловсруулж, ТЕГ-аас санал авч, нууцын журмаар батлуулав.<br>2021 оны нууцын зэрэглэлтэй албан бичгүүдийг архивын нэгж болгон архивлав.<br>ЭМЯ-ны харьяа Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II, Амгалан, Өргөө, Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт Төрийн болон албаны нууцын тухай хууль, Журам батлах тухай Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, уг тогтоолд заасны дагуу нууц | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгаалах ажилтанг томилон ажиллуулах, нууцтай танилцах эрх бүхий албан хаагчдын жагсаалтыг баталж, аюулгүй байдлын шалгалтад хамруулах, байгууллагын нууц хадгалах, хамгаалах журмыг боловсруулж, батлах, нууцыг хадгалах, хамгаалах өрөө, биет хамгаалалтын бэлэн байдлыг хангаж ажиллах талаар 2022 оны 3/4913 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2022 онд төрийн болон албаны нууцтай холбоотойгоор 42 албан хаагчаас нууц задруулахгүй баталгааг гаргуулан авч бүртгэлийг хөтлөв. | |
| 179. | Яамны газар, хэлтсээс боловсруулж баримт бичгүүдийг хянаж, хууль тогтоомжид нийцүүлж гаргана. | Хянасан эрх зүйн баримт бичгийн тоо | Хуулийн хэлтэс эрх зүйн баримт бичгүүдийг хянадаг. | Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, аппаратын ажилтнуудад хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан байна. | I-IV улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн Сайд, Төрийн нарийн бичгийн даргын батлан гаргах тушаалуудын төслийг хянан боловсруулсан мэргэжилтнүүдэд хуулийн үндэслэлийг хэрхэн сонгох талаар зөвлөгөөг тухай бүрт нь өгч ажилласан.<br>Хянасан тушаал, шийдвэр – нийт 680, Сайдын тушаал – 480, Төрийн нарийн бичгийн даргын тушаал – 200 | 100 |
| 180. | Яамны болон харьяа байгууллагуудын албан хаагчдын 2021 оны ХОМ-ийг хүлээн | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөх | Хуульд заасан хугацаанд холбогдох | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөх ёстой төрийн албан | I улирал | ТЗУГ | ЭМЯ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн 553 албан тушаалтан хуулийн хугацаанд | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | авах үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлан гаргана. | ёстой төрийн албан хаагчдын мэдүүлэг гаргасан хувь | албан тушаалтну удын хөрөнгө орлогны мэдүүлгийг хянаж хүлээн авдаг. | хаагчид 100 хувь хуулийн хугацаанд мэдүүлэг гаргасан байна. | | | багтаан АТГ-ын meduuleg.iaac.mn цахим хуудсанд ХАСХОМ-ийг хугацаанд нь бүрэн мэдүүлсэн. ХАСХОМ-ийг хүлээн авах үйл ажиллагаанд хяналт тавьж, нэгдсэн тайланг ХАСХОМ-3, ХАСХОМ-4, ХАС хураангуй, ХОМ хураангуй гэсэн 4 төрлөөр гаргаж, АТГ-т 2022 оны 2/803 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>АТГ-т шинээр томилогдох 63 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг нэгтгэн боловсруулж, цахимаар хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг илгээж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу дүгнэлт гаргуулсан.<br>“Өргөө амаржих газар”, “Хүрээ амаржих газар”, “Амгалан амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд Эрүүл мэндийн яамны харьяанд ирсэнтэй холбоотойгоор эмнэлэг тус бүрт ЭБАТ томилон, эрхийг нь системд үүсгэж, шинээр томилогдсон ЭБАТ-ыг мэргэжлийн арга зүйгээр хангаан ажилласан. Тус | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эмнэлгүүдийн ТҮЭМ-6, ТҮЭМ-7, ТҮЭМ-8-ийн удирдах албан тушаалтнууд анх удаа ХАСХОМ мэдүүлсэн. | |
| 181. | Эрх зүйн маргаанд Эрүүл мэндийн яамыг төлөөлж, хэрэг маргаанд оролцсон байна. | Шүүхээр бүрэн шийдвэрлүүлсэн эрх зүйн маргааны тоо | ЭМЯ-тай холбоотой эрх зүйн маргааныг яамыг төлөөлж оролцдог | ЭМЯ-тай холбоотой эрх зүйн маргааныг хуулийн дагуу шийдвэрлүүлсэн байна. | I-IV улирал | ТЗУГ | ТЗУГ-ын ХХ нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 5, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд давж заалдах шатны шүүхэд 4, Дээд шатны хяналтын шүүхэд 2, АТГ-аас ирүүлсэн саналын дагуу Эрүүгийн 2 хэрэгт эрх зүйн маргаанд он дамнан ЭМЯ-аас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна.<br>2022 онд шинээр 7 эрх зүйн маргаанд томилогдож, 48 удаа шүүх хуралдаанд оролцсон. Үүнээс:<br>Иргэний хэргийн анхан шатны шүүхээр хэлэлцэгдсэн 9 эрх зүйн маргаанд хариу тайлбарыг бичиж, нотлох баримтыг бүрдүүлж хүргүүлсэн.<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээр хэлэлцэгдсэн 14 эрх зүйн маргаанд хариу тайлбарыг бичиж, нотлох баримтыг бүрдүүлсэн.<br>Нийт иргэний 3 хэрэг, Захиргааны 9 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн.<br>2022 онд 15 маргаанаас 2-т нь | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ялж, 2 ялагдаж, 11 үргэлжлээд явж байна. | |
| 182. | Яамны архивын журмыг шинэчлэн батлуулна. | Шинээр батлагдсан журам | 2013 оны журмыг мөрдөж байна. | Яамны архивын журмыг шинэчлэн батлуулсан байна. | I улирал | ТЗУГ | Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/19 дүгээр тушаалаар архивын журмыг шинэчлэн батлуулж мөрдөж байна.<br>2022 оны 1-12 сард нийт 370 байгууллага, иргэнд үйлчилж 13217 хуудас лавлагаа, хуулбарыг цаасан болон цахим хэлбэрээр олгож, хуулбар үнэн дардсыг 1946 хуудас баримтанд дарж нотлох баримтын шаардлага хангаан хүргүүлсэн. 950 орчим хадгаламжийн нэгж, 190.000 гаруй хуудас баримтад үзлэг хийсэн. Яамны албан хаагчдаас 2021 оны нийт 750 ширхэг /150.000 орчим хуудас/ баримтыг хүлээн авч үдэж хавтаслан бүртгэлд оруулсан. | 100 |
| 183. | Эйбл програмаар дамжуулан ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийг бүрэн цахимжуулна. | Эйбл програмаар хүлээн авсан, явсан албан бичгийн тоо | Албан бичиг шийдвэрлэлт цаасаар давхар явж байна. | Албан бичиг шийдвэрлэлт бүрэн цахимжсан байна. | I-II улирал | ТЗУГ | Тус яаманд 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 11491 албан бичиг, 1100 өргөдөл гомдол ирсэн нь 100 хувь эйблд бүртгэгдсэн байна. ЭМЯ-аас явсан 5811 бичиг, 94 өргөдөл гомдлын хариу эйблд бүртгэгдсэн. | 100 |
| 184. | Тоон гарын үсэг нэвтрүүлнэ. | Тоон гарын үсэг хэрэглэж буй албан | | Албан бичиг шийдвэрлэлтэд цаасгүй болон тоон гарын үсэг | I-IV улирал | ТЗУГ | Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг нэгдсэн байдлаар тоон гарын үсэг олгох ажиллагааг зохион | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хаагчийн тоо | | ашигладаг болсон байна. | | | байгуулах саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2022 оны 4/4032 тоот албан бичгээр байгууллагын жагсаалт, хаяг, албан хаагчийн тооны хамт хүргүүлсэн.<br>2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 16 аймгийн 10,821, нийслэлийн СХД, Багануур дүүргийн 239 нийт 11,060 эмч эмнэлгийн мэргэжилтэнд тоон гарын үсгийн “токен” олгоод байна. | 0 |
| 6. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийн зарцуулалтад хяналт, шалгалт, дотоод аудит хийх. | | | | | | | | |
| 185. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2021, 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд хүргүүлдэг. | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I, IV улирал | ХШҮДАГ | МУ-ын2021-2025 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/197 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлж, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д оруулж баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 74.62 хувь, ЗГХЭГ-ын үнэлгээ 65.38 хувь болж | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эцэслэгдсэн. | |
| 186. | МУ-ын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд хүргүүлдэг. | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Эрүүл мэндийн салбарын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг 1а/197 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. ЭМЯ-ны үнэлгээ 79.4 хувьтай. | 100 |
| 187. | МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн, 2022 оны хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I, II, IV улирал | ХШҮДАГ | ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Дүнг 1а/194 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 76.7 хувь, ЗГХЭГ-ын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлгээ 75.1 хувь болж эцэслэгдсэн.<br>ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2022 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/3169 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 44.5 хувьтай.<br>ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2022 оны эхний 10, 11 сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 57.3 хувь, 60.6 хувьтай. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 188. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | I, III улирал | ХШҮДАГ | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, дүнг 1а/648 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЭМЯ-ны үнэлгээ 86.8 хувь, ЗГХЭГ-ын үнэлгээ 83.7 хувь болж эцэслэгдсэн.<br>2022 оны I улирлын байдлаар эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй ЗГ-ын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг 2022 оны 2/2429 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан http://new.unelgee.gov.mn/law/-д баталгаажуулсан.<br>Хэрэгжиж дууссан, нэг удаагийн шинжтэй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон зэрэг 86 шийдвэрийн 112 заалтыг ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтаас хасуулах саналыг 2022 оны 2/2694 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2022 оны эхний хагас жилийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/3308 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан http://new.unelgee.gov.mn/law/-д баталгаажуулсан.<br>ЗГ-ын шийдвэрийн хэрэгжилтэд 2022 оны 08, 09, 10, 11 дүгээр сарын байдлаар тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн сан http://new.unelgee.gov.mn/law/-д баталгаажуулсан. | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 189. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Дотоод аудитын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийнэ. | Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан | Тайланг тогтсон хугацаанд СЯ-нд хүргүүлдэг. | Тайланг СЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | I-IV улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/128 дугаар тушаалаар Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын хорооны бүрэлдэхүүнийг баталсан. 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан Дотоод аудитын хорооны анхдугаар хурлаар “Аудитын 2022 оны төлөвлөгөө”-г хэлэлцүүлж, Дотоод аудитын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>“Аудитын 2022 оны төлөвлөгөө”-нд 21 ажил төлөвлөснөөс санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын 14 (93.6%), бусад 7 (98.6%) ажлыг гүйцэтгэж, хэрэгжилт 95.2 хувьтай байна. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлсан 6 санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. | 95 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 190. | Эрүүл мэндийн яамны 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн яамны 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/1425 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЭМЯ-ны үнэлгээ 74.7 хувь, ЗГХЭГ-ын үнэлгээ 78.69 хувь болж эцэслэгдсэн. | 100 |
| 191. | Эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргадаг. | Тайланг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЭМЯ-ны харьяа байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг нийслэлийн ЭМГ, БОЭТ-д 2022 оны 8/1007, 8/1028-1075 тоот албан бичгээр хүргүүлж, 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдөр эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөнд танилцуулсан. | 100 |
| 192. | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | I улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн салбарт гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа 54 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг 2022 оны 1а/842 тоот албан | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийнэ. | | | | | | бичгээр СЯ-нд хүргүүлсэн (үнэлгээ 83.3 хувьтай). | |
| 193. | Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | II улирал | ХШҮДАГ | 8 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/1456 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэн, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. | 100 |
| 194. | “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | II улирал | ХШҮДАГ | “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Дүнг 1а/2020 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 64.4 хувьтай. | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 195. | МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд хүргүүлдэг. | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | II, IV улирал | ХШҮДАГ | МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, дүнг 3/2898 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлж, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж, баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 40.5 хувьтай. МУ-ын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд 9, 10, 11 дүгээр сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулж, баталгаажуулсан. ЭМЯ-ны үнэлгээ 51.1, 55.1, 63.8 хувьтай. | 100 |
| 196. | Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтэд 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | II, III улирал | ХШҮДАГ | Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/1417 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. (үнэлгээ 82.2 хувьтай) Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. (хагас жилийн хэрэгжилт 61.4%) | |
| 197. | “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЭЗХЯ-нд хүргүүлдэг. | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | III улирал | ХШҮДАГ | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, 2/3184 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. (үнэлгээ 58.5 хувьтай)<br>“Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд 2022 оны эхний 11 сарын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг 1а/5300 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, ЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д баталгаажуулсан. (үнэлгээ 62.8 хувьтай) | |
| 198. | МУ-ын Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар зарлигийн дагуу ҮАБЗ-ийг холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлнэ. | Танилцуулах мэдээлэл | Мэдээллийг тогтсон хугацаанд ҮАБЗ-д хүргүүлдэг. | Мэдээллийг ҮАБЗ-д хугацаанд нь хүргүүлсэн байна. | II, IV улирал | ХШҮДАГ | ҮАБЗ-ийг холбогдох мэдээллээр хангах хүрээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ; Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтийн тухай мэдээ, тайлан; Эрүүл мэндийн салбарт шинээр болон шинэчилсэн стандартуудын тухай танилцуулах мэдээг 2/3359 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>11 төрлийн мэдээллийг ҮАБЗ-д 2022 оны жилийн эцсийн болон сүүлийн хагас жилийн байдлаар хүргүүлэхээр яамны холбогдох газрууд, эрүүл мэндийн байгууллагуудад дотоод меморандум, албан бичиг хүргүүлсэн. 2022 оны 12 дугаар сард багтаан ҮАБЗ-д хүргүүлнэ. | 100 |
| 199. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын дүн | Тайлан | Тайланг тогтсон хугацаанд СЯ-нд хүргүүлдэг. | Тайланг СЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | Улирал тутам | ХШҮДАГ | 2022 оны 1 дүгээр улиралд Шилэн дансны мэдээлэл https://shilendans.gov.mn/ цахим санд ЭМЯ-ны байршуулсан мэдээлэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Нийт 75 мэдээлэл байршуулахаас 22 мэдээлэл хуулийн хугацаа | 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хоцроон байршуулж 25 мэдээллийг цахим санд байршуулаагүй байсан. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг СЭЗГ-т 2022.03.14-ний өдрийн Дотоод меморандум №23, 2022.04.08-ны өдрийн Дотоод меморандум №34, 2022.05.13-ны өдрийн Дотоод меморандум №56-ыг хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 19 байгууллагуудын 2022 оны Шилэн дансны мэдээлэл https://shilendans.gov.mn/ цахим санд нэгтгэгдсэн.<br>Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 169 байгууллагын Шилэн дансны мэдээлэл 2022 оны 11 дүгээр сарын байдлаар https://shilendans.gov.mn/reportorgs цахим санд нэгтгэгдэн 80 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>СЭЗГ-т нийт 7 удаагийн Дотоод меморандум хүргүүлснээр цахим санд байршуулаагүй байсан 26 мэдээллийг нөхөн байршуулсан. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар Төсвийн ерөнхийлөн захирагч болон Төсвийн шууд захирагчийн шилэн дансанд байршуулах 273 мэдээллээс | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах үндсэн нэгж | Хэрэгжилт | Хэрэгжилт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 207 мэдээллийг хуулийн хугацаанд, 66 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын мэдээллийг https://shilendans.gov.mn/reportorgs цахим санд нэгтгэгдсэн. | |
| | | | | | | | | 76,1 |

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 12 дугаар сарын 23

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 76,1 хувийн үнэлгээтэй гэж үзэх

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 0-50 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 59 үйл ажиллагааг Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангахыг газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгох

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ц.ЭРДЭМБИЛЭГ

# ДОТООД МЕМОРАНДУМ № 204

---

Хэнд: 1. Төрийн захиргааны удирдлагын газарт
2. Бодлого төлөвлөлтийн газарт
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний газарт
4. Нийтийн эрүүл мэндийн газарт
5. Санхүү, эдийн засгийн газарт

Хэнээс: Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас

Утга: Эрүүл мэндийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн, Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр хүргүүлэх тухай

Огноо: 2022 оны 12 дугаар сарын 26

Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалд заасанчлан ЭМЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба үнэлгээний дүнг, хурлын шийдвэрийн хамт хүргүүлж байна. Үнэлгээгээр 0-50 үнэлэгдсэн ажлууд болон зайлшгүй шаардлагатай бусад үйл ажиллагааг 2023 оны төлөвлөгөөнд тусгаж, эрчимжүүлж ажиллана уу.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА С.ТӨГСДЭЛГЭР

Боловсруулсан Т.Болорчимэг